

Эрүүл мэндийн сайдын
..... оны.....сарын.....ны өдрийн
.....дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмнэлгийн эм зүйн алба, нэгжийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлох, эм зүйн тусламж үйлчилгээг багаар үзүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмийн эмчилгээний үр дүнг хянах, чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2. Энэхүү дүрмийг эмнэлгийн эм зүйн алба, нэгж мөрдөнө.
- 1.3. Эмнэлгийн Эм зүйн алба, нэгж нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эмнэлзүйн эм зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх гэсэн үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулна.
- 1.4. Монгол Улсын “Эрүүл мэндийн тухай” хууль, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”, “Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016” стандарт, Эрүүл мэндийн сайдын баталсан холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.5. Эмнэлгийн Эм зүйн алба, нэгж нь энэхүү үлгэрчилсэн дүрмийг үндэслэж, стандарт ажиллагааны заавар гаргаж ажиллаж болно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Эмнэлгийн хүчин чадал, хүний нөөцөөс хамааран эм зүйн алба, нэгж нь дараах бүрэлдэхүүнтэй байна: Эм зүйн албаны дарга, эмнэлзүйн эм зүйч /50 оронд 1-2/, жор баригч эм зүйч, эм найруулагч;

2.2. Эм зүйн албаны даргын ажил үүрэг:

- 2.2.1. Эм зүйн албаны мэргэжлийн ур чадварыг сайжруулах, дадлагажуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- 2.2.2. Эм зүйн албаны үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэх, сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

- 2.2.3. Эм зүйн албаны хүний нөөцийн хөгжлийг төлөвлөх, тасралтгүй сургалтыг зохион байгуулах;
- 2.2.4. Эм зүйн алба, нэгжийн журам, үйл ажиллагааны заавар боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, шинэчлэх ажлыг хийж чанарын албаар хянуулах;
- 2.2.5. Эрүүл мэнд, эм зүйн салбарын журмын анхан шатны бүртгэл, баримт хөтлөлтийг хянах, тайланг мэдээлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- 2.2.6. Эм зүйн алба, нэгжийн үйл ажиллагааны чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зохион байгуулах, хянах;
- 2.2.7. Эмнэлгийн удирдлага, Чанар аюулгүй байдлын алба, Эрсдэлийн удирдлагын багт эмийн хэрэглээ, чанар аюулгүй байдлын тайланг тайлагнах, авах арга хэмжээг зохион байгуулахад оролцох;
- 2.2.8. Эмийн зардалд дүн шинжилгээ хийж, Санхүүгийн алба зэрэгт удирдлагын багт шаардлагатай санхүүгийн мэдээллээр хангах;
- 2.2.9. Эмнэлэгт хэрэглэх эмийн жагсаалт, эмийн лавлах боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах, эмийн хэрэглээнд хяналт тавих;
- 2.2.10. Эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, нийлүүлэх, зарцуулалтыг төлөвлөх, хянах, үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- 2.2.11. Эмнэлгийн эмийн агуулахын менежментийг хянах үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- 2.2.12. Эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн мастер мэдээллийн сан бүрдүүлэх, эмийн мэдээлэл нэмэх, хасах, хянан зохицуулах;
- 2.2.13. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн худалдан авалт, хадгалалт, зарцуулалтад хяналт тавих;
- 2.2.14. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх;
- 2.2.15. Эмийн гаж нөлөөг эрт илрүүлэх, бүртгэн мэдээлэх, үнэлэх, урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээг удирдан зохион байгуулах;
- 2.2.16. Эмийн эмчилгээний алдааг илрүүлэх, бүртгэн мэдээлэх, үнэлэх, урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээг зохион байгуулах, удирдлагаар хангах;
- 2.2.17. Эмийн чанарын асуудлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээг зохион байгуулах, удирдлагаар хангах;
- 2.2.18. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар хэлэлцүүлэг хийж, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
- 2.2.19. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд шинэ эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээлэл хийх ажлыг зохион байгуулах, удирдлагаар хангах;

2.3. Эмнэл зүйн эм зүйчийн ажил үүрэг:

- 2.3.1. Хэвтэн үйлчлүүлэгчийн эмийн жор, захиалгыг үнэлэх, захиалгын хяналт хийх;

- 2.3.2. Эмчлэгч эмчийг эмийн эмчилгээтэй холбоотой мэдээллээр хангах, эмийн эмчилгээг шийдвэрлэхэд оролцох;
- 2.3.3. Эмнэлэгт хэрэглэх эмийн жагсаалт, эмийн лавлах боловсруулах, эмийн хэрэглээнд хяналт тавих;
- 2.3.4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээнд хяналт тавих;
- 2.3.5. Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, үнэлэх;
- 2.3.6. Эмийн эмчилгээний алдааг бүртгэн мэдээлэх, үнэлэх, авах арга хэмжээнд оролцох;
- 2.3.7. Эмийн чанарын асуудлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээг зохион байгуулах;
- 2.3.8. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар хэлэлцүүлэг хийж, зөвлөгөө өгөх;
- 2.3.9. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд шинэ эм, эмийн бүтээгдэхүүний мэдээлэл хийх;

2.4. Жор баригч эм зүйчийн ажил үүрэг:

- 2.4.1. Эмнэлэгт хэрэглэх эмийн жагсаалт, эмийн лавлах боловсруулах үйл ажиллагаанд оролцох;
- 2.4.2. Тасгийн эмийн захиалга, хэрэгцээ, нөөц, зарцуулалтын хяналтыг хийж, эмийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг хянах;
- 2.4.3. Эмнэлгийн эм, бэлдмэлийг худалдан авалт, нийлүүлэх, зарцуулалтын бүртгэл хөтлөх, тайлан гаргах;
- 2.4.4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалга, хадгалалт, зарцуулалтын хяналт, бүртгэл, тайланг гаргах;
- 2.4.5. Ууж хэрэглэх шингэн эмийн найрлагыг шалгах, хянах;
- 2.4.6. Эмнэлгийн эм, эмийн бүтээгдэхүүний мэдээллийн сан бүрдүүлэх, эмийн мэдээлэл нэмэх, хасах, хянан зохицуулах;
- 2.4.7. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд шинэ эм, эмийн бүтээгдэхүүний мэдээлэл хийх ажлыг зохион байгуулахад оролцох;
- 2.4.8. Эмийн чанарын асуудлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээг зохион байгуулах;

2.5. Эм найруулагчийн ажил үүрэг:

- 2.5.1. Захиалгын дагуу үйлчлүүлэгчдийн эмийг нэгж тунгийн системээр бэлтгэх;
- 2.5.2. Тасгийн эмийн нэгдсэн захиалгыг багцалж, хариуцсан тасгийн ахлах сувилагчид хуваарьт цагийн дагуу хүлээлгэн өгөх;
- 2.5.3. Эмнэлэгт хэрэглэх ариутгалын бодисыг захиалгын дагуу найруулах, бэлтгэх;
- 2.5.4. Ууж хэрэглэх шингэн эмийг захиалгын дагуу найруулах, бэлтгэх;
- 2.5.5. Хариуцсан ажлын анхан шатны бүртгэлүүдийг хөтөлж, тайлан гаргах;

2.5.6. Хариуцсан үйл ажиллагаатай холбоотой эм, бараа, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллах;

2.5.7. Эм зүйн үйл ажиллагааны талбарыг цэвэрлэх;

2.6. Эмнэлгийн эмзүйн алба нь эм зүйн тусламж үйлчилгээнд шаардагдах журамнууд болон стандарт ажиллагааны зааврыг боловсруулан мөрдөж ажиллана.

2.7. Эм зүйн албаны төлөөлөл нь Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хорооны гишүүн байх ба тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг тодорхойлж, чанарын шаардлага хангасан, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангах, эмийг зохистой хэрэглэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.8. Эм зүйн албаны дарга нь Антибиотикийн хөтөлбөрийг хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.9. Эмнэлэг бүр өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон эмнэлгийн эмийн жагсаалттай байна.

Гурав. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа

Эм зүйн алба эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах чиглэлээр ажиллана.

3.1. Эм зүйн албаны баг нь эмийн хадгалалт, түгээлт болон олголтод хариуцлага хүлээж, Эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014 стандартын шаардлагыг мөрдөж ажиллана.

3.2. Эм зүйн албаны ажилтан бүр эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмийн тасалдал үүсэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, яаралтай тохиолдолд шаардлагатай эмээр хангаж ажиллана.

3.3. Нийлүүлэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн тоо ширхэг, цувралын дугаар, чанарын баталгаажилтыг шалган, орлогын бүртгэлд бүртгэж, нөөцийн агуулахад эмх цэгцтэй хадгалах, савлаж бэлдсэн эмэнд давхар хяналт тавих, хэрэглээний явц, байдалд хяналт тавьж баримтжуулах үүргийг мэргэжлийн багийн эм зүйч хариуцан ажиллана.

3.4. Нөөцийн тасаг нь эмийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын зөв горим дэглэмийг баримтлан эмийн хугацаа дуусах, чанар байдал өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлнэ.

3.5. Тухайн эмнэлэг өөрийн бүтэц үйл ажиллагааны онцлогоос хамаарч эм түгээх, олгоход дараах системийг дангаар нь болон хослуулан хэрэглэнэ.

3.5.1. Эмийн нөөц, агуулах, нөөц дүүргэлтийн систем: Яаралтай байдалд үйлчлүүлэгчийн амь насыг авран хамгаалах зорилгоор тасагт шаардлагатай эм бэлдмэлийг нөөцлөнө. Ердийн тохиолдолд тасгийн захиалгаар эм бэлдмэлүүдийг нөөц агуулахаас хуваарилна.

3.5.2. Өндөр эрсдэлт эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгын систем: Тухайн үйлчлүүлэгчид бичсэн эмчийн заалт, жорын дагуу эмийг түгээнэ.

3.5.3. Нэгж тунгийн олголтын систем: Эм бэлдмэлийг үйлчлүүлэгч бүрт зориулан нэгж тунгаар зориулалтын машинаар болон гараар савлан хаяглаж олгоно. Савласан эмийг тасагт хүргэх, үйлчлүүлэгч эм хэрэглэх асуудлыг сувилагч хариуцаж, үйлчлүүлэгчид хэрэглэсэн болон эмийн сан руу буцаах эм бэлдмэлийн цувралын дугаар, хаягжилт зэргийг тодорхойлж баримтжуулах.

3.5.4. Цахим эм олголтын систем: Үйлчлүүлэгч бүрт тохирсон нэгж тунгаар хуваарилах үйл ажиллагааг цахим системд тулгуурлан гүйцэтгэнэ.

3.5.5. Цахим жор: Эмч жорыг эм зүйн алба руу цахим жорын системээр дамжуулан илгээнэ.

3.6. Эм зүйн албаны ажилтан бүр эмийн түгээлтэд гарах аливаа эрсдэлээс сэргийлэх, эмийн чанар, аюулгүй байдалтай холбоотой асуудал үүссэн тохиолдолд эмийг эргүүлэн татах боломжийг бүрдүүлэх зорилгоор эмийг хянах системийг хэрэгжүүлнэ.

3.7. Эм зүйч эмчилгээний эхний тунг үйлчлүүлэгчид хэрэглэхийн өмнө бүх эм бэлдмэлийг олгосон болон нэмж захиалах эсэхийг эмийн эмчилгээний хуудсыг ашиглан хянана.

3.8. Эмчилгээг өдөр тутам хянахдаа: эмийн бүртгэлийг цаасаар эсвэл цахимаар хөтлөх, үйлчлүүлэгч бүрт олгосон, хэрэглэсэн болон буцаагдсан эмийн тоо хэмжээг харьцуулан хянах замаар хэрэгжүүлнэ.

3.9. Агуулах ба тасгийн хяналт шалгалт

3.9.1. Эмийн тээвэрлэлт, тусгай хадгалалтын горим, хугацаа, эм хадгалж буй орчинд хяналт тавина.

3.9.2. Хяналтын явцад илэрсэн аливаа зөрчлийг засах арга хэмжээг бүртгэж сайжруулан ажиллана.

3.10. Эм, найруулах, бэлтгэх

3.10.1. Эм найруулах, бэлтгэх өрөө нь эм зүйн болон эрүүл ахуйн стандартын шаардлага, аюулгүй байдлыг хангасан байна.

3.10.2. Эм найруулагч тухайн ээлжийн эмчилгээнд зориулж эмийг найруулах, дахин савлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.10.3. Эм найруулагч нь зохих стандарт арга ажиллагааны зааврын дагуу эмийг найруулж бэлтгэн, эм шалгагчид хянуулан, баталгаажуулсны дараа тасгуудад хүлээлгэн өгнө.

3.10.4. Эс хордуулах болон хортой эмийг бэлтгэж, найруулахад стандарт үйл ажиллагааны зааврыг мөрдөнө.

Эмийн жорыг хянах, зохицуулах үйл ажиллагаа

Үйлчлүүлэгчдийн эмийн эмчилгээнд эмнэл зүйн эм зүйч үнэлгээ хийж, үйлчлүүлэгч бүрд тохирсон эмийн эмчилгээг төлөвлөх, хянах, эмийн аюулгүй байдалтай холбоотой үүсэх эрсдэлийг илрүүлэх, авах арга хэмжээг зохицуулна.

Нэг. Эмийн жорын хяналт хийх үйл явц

- 1.1. Эмнэл зүйн эм зүйч тасгийн тойрон үзлэгт оролцож, үйлчлүүлэгчид эм хэрэглэх заалт, эмийн сонголт, тун, хэрэглэх арга, эмийн эмчилгээний хяналтын асуудалд санал солилцох, зөвлөж ажиллана.
- 1.2. Эмнэлэгт хэвтэн үйлчлүүлэгчдэд төлөвлөсөн эмийн эмчилгээний хуудсанд үзлэг хийж, эмчлүүлэгчийн мэдээлэл, өвчний түүх, онош, эмнэл зүй, шаардлагатай шинжилгээний дүнд үндэслэн эмийн эмчилгээг хянаж ажиллана.
- 1.3. Шаардлагатай тохиолдолд эмийн сонголт, тун, тунгийн дэглэмд эмчид санал тавьж (Хүснэгт 1), үйлчлүүлэгчид тохирсон эмчилгээг төлөвлөхөд хамтарч ажиллан, эмээс шалтгаалах эрсдэлээс сэргийлнэ.
- 1.4. Эмнэл зүйн эм зүйч үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтсэн даруйд, 24 цагийн дотор эмийн эмчилгээний хуудсанд эхний үнэлгээг хийнэ.
- 1.5. Цаашид дараах тохиолдолд давтан үзлэг, хяналтыг хийнэ:
 - 1.5.1. Эмчилгээнд өөрчлөлт орсон тохиолдол бүрд;
 - 1.5.2. Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасагт өдөр бүр;
 - 1.5.3. Хэвтэн эмчлүүлэх тасагт 3 хоногт 1 удаа;
- 1.6. Эмийн жорын үнэлгээг “Эмийн жорын хяналтын хуудас”-ны дагуу хийнэ (Хүснэгт 2).
- 1.7. Эмчилгээний хуудсанд эмийг үйлчлүүлэгчид олгосон, тарилга, дуслыг хийсэн сувилагчийн тэмдэглэлийг хянаж, шаардлагатай тохиолдолд эмчийн бичсэн эмийн эмчилгээтэй тулгаж үзэх, үйлчлүүлэгч эм хэрэглээгүй орхигдсон тохиолдол болон шалтгааныг хянана.
- 1.8. Эмчилгээний хуудсанд хяналт хийсэн тухай болон эмийн эмчилгээнд илэрсэн эрсдэл, гаж нөлөө, харшлын тухай тэмдэглэлийг үйлчлүүлэгчийн өвчний түүхэнд бичнэ.


- 1.9. Эмийн жорын хяналтын дүнд илэрсэн асуудал болон авах арга хэмжээг “Эмийн жорын хяналтын дагуу авах арга хэмжээ”-ний хуудсаар эмчлэгч эмчид танилцуулж, санал солилцон зөвшилцсөний дүнд тухайн өдөртөө багтаж, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.10. Эмнэл зүйн эм зүйч авах арга хэмжээний хэрэгжилтийг хянаж, эмийн эмчилгээний хяналт (Хүснэгт 3) болон хэрэгжүүлсэн арга хэмжээг (Хүснэгт 4) эм зүйн албаны мэдээний санд бүртгэнэ.

Хоёр. Үйлчлүүлэгчийн эмийн жорын хяналтын дагуу авах арга хэмжээ

- 2.1. Эм зүйн албаны дарга “Эмийн жорын хяналтын мэдээний сан”-д дүн шинжилгээ хийж, тайланг жилийн эцэст эмнэлгийн Эмийн эмчилгээг зохицуулах хороонд тайлагнана.
- 2.2. Эм зүйн албаны дарга “Эмийн жорын хяналтын мэдээний сан”-гийн тайлан болон үйлчлүүлэгч бүрд тохирсон эмийн эмчилгээг төлөвлөх, хянах, эмийн аюулгүй байдалтай холбоотой үүсэх эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хуваарийн дагуу нийт эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлэл хийнэ.
- 2.3. Эмчилгээний алдааны тохиолдол болон алдаа үүсэх эрсдэл илэрвэл эмчлэгч эмч эсвэл жижүүрийн эмчид мэдэгдэн, журмын дагуу зохих арга хэмжээг авна.
- 2.4. Эмэнд хэт мэдрэгшил үүссэн, гаж нөлөө илэрсэн тохиолдолд эмчлэгч эсвэл жижүүрийн эмчид мэдэгдэн, зохих арга хэмжээг авсны дараа “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”-ын дагуу зохицуулна.

Хүснэгт 1.

Үйлчлүүлэгчийн эмийн жорыг хянах, зохицуулах үйл ажиллагааны урсгал



Хүснэгт 2.

Үйлчлүүлэгчийн эмийн жорын хяналт хийх үйлдлийн дараалал		Үнэлгээ
I. Эмийн жор бичилт:		
1	Эмнэлгийн эмийн жагсаалтад орсон эмийг эмчилгээнд төлөвлөсөн	☐ Тийм, ☐ Үгүй
2	Эм хэрэглэх заалт	☐ Тийм, ☐ Үгүй
3	Эм хэрэглэх эсрэг заалт (жирэмсэн, өндөр настан, эмнэл зүйн онцлог) байхгүй	☐ Тийм, ☐ Үгүй
4	Өвчний эмчилгээний удирдамжид заасан эм хэрэглэсэн	☐ Тийм, ☐ Үгүй

5	Үйлчлүүлэгчийн эмийн харшлын болон өмнө хэрэглэсэн эмийн түүхийг харгалзсан	☐ Тийм, ☐ Үгүй
6	Эмийн эмчилгээг жорын стандартын дагуу бичсэн	☐ Тийм, ☐ Үгүй
7	Эмийн тун, хэрэглэх арга үйлчлүүлэгчийн биеийн жинд тохирсон	☐ Тийм, ☐ Үгүй
8	Элэг, бөөрний үйл ажиллагааны байдалд тохирсон	☐ Тийм, ☐ Үгүй
9	Эмийн эмчилгээ өвчний эмнэл зүйд тохирсон	☐ Тийм, ☐ Үгүй
10	Эмийн давхцал үүсээгүй	☐ Тийм, ☐ Үгүй
11	Эм-эмийн харилцан үйлчлэл үзүүлэх эм хамт бичигдээгүй	☐ Тийм, ☐ Үгүй
II. Эм хэрэглэх шат:		
1	Эмийн захиалга хугацаандаа хийгдсэн, эмчилгээнд хэрэглэгдсэн	☐ Тийм, ☐ Үгүй
2	Эмийг зааврын дагуу зөв хэрэглэсэн	☐ Тийм, ☐ Үгүй
3	Эмийн эмчилгээг хийсэн сувилагчийн тэмдэглэл	☐ Тийм, ☐ Үгүй
4	Хэрэглээгүй орхигдсон эм байхгүй	☐ Тийм, ☐ Үгүй
III. Эмийн эмчилгээний хяналтын шат:		
1	Эмийн эмчилгээний үр нөлөөг хянасан (эмнэл зүй)	☐ Тийм, ☐ Үгүй
2	Эмчилгээнд хэрэглэж буй эмийн цусан дахь концентрац хянасан (шаардлагатай үед)	☐ Тийм, ☐ Үгүй
3	Лабораторийн шинжилгээгээр хяналт хийсэн	☐ Тийм, ☐ Үгүй
4	Шинээр эмийн харшил, харилцан нөлөөлөл, гаж нөлөө илэрсэн	☐ Тийм, ☐ Үгүй
5	Илэрсэн гаж нөлөөний эсрэг хийсэн эмчилгээний арга хэмжээг өвчний түүхэнд тэмдэглэсэн	☐ Тийм, ☐ Үгүй
IV. Үйлчлүүлэгчээс эмийн эмчилгээний талаар анамнез авах, зөвлөгөө өгөх:		
1	Үйлчлүүлэгч хэрэглэж буй эмийн талаарх мэдлэгтэй эсэх	☐ Тийм, ☐ Үгүй
2	Эм хэрэглэх аргын талаар мэдлэгтэй эсэх	☐ Тийм, ☐ Үгүй
3	Ууж хэрэглэсэн эмийг зөв хэрэглэсэн байдал	☐ Тийм, ☐ Үгүй
4	Эмчилгээнд хэрэглэж буй эмийн талаар, эмийг зөв, аюулгүй хэрэглэх зөвлөгөөг өгөх	☐ Тийм, ☐ Үгүй

Хүснэгт 3.

Үйлчлүүлэгчийн эмийн жорын хяналтын хуудас

(Medication review form)

Хяналт хийсэн он сар өдөр		☐ Анхны хяналт
Үйлчлүүлэгчийн нэр/Түүхийн дугаар		☐ Давтан хяналт
Эмчлэгч эмчийн нэр:		Төрсөн он, сар, өдөр
Эм зүйчийн нэр:		
Өмнөх эмийн түүх		Харшлын түүх

Эмийн эмчилгээний мэдээлэл (Одоогийн)						
Эмийн нэр	Хэрэглэсэн арга, тун	Эхэлсэн огноо	Зогсоосон огноо	Заалт (Эсрэг заалт?)	Эмийн харилцан нөлөөлөл	Дэглэм мөрдөлт (Сайн/Муу)
1.						
2.						
3.						
4.						
5.						
6.						
7.						
8.						
9.						
10.						
Шинжилгээ/Амин үзүүлэлт						
Үзүүлэлт	Хэвийн хэмжээ	Хариу	Үзүүлэлт	Хэвийн хэмжээ	Хариу	
Холестерин			Глюкоз			
БНЛХ			HbA1C			
Триглицерид			Бусад			
Na ⁺			АД			
K ⁺			Пульс			
Үйлчлүүлэгчээс асуумж авах, зөвлөгөө өгөх						
Эмийн зориулалтыг мэдэх үү?		Өөрөө эм авч хэрэглэсэн үү?		Хоолны зөвлөгөө өгсөн үү?		
Эмчилгээний үр дүн мэдэх үү?		Гаж нөлөө илэрсэн үү?		Эм уух заавар өгсөн үү?		
Эмчлэгдээгүй зовуурь байна уу?		Эм хэрэглэхэд хүндрэл байна уу?		Хориглох хүнсийг зөвлөсөн үү?		
Тамхи татдаг уу?		Эм уух цагийг сануулсан уу?				

Хүснэгт 4.

Үйлчлүүлэгчийн эмийн жорын хяналтын дагуу авах арга хэмжээ

Хяналт хийсэн он сар өдөр		☐ Анхны хяналт ☐ Давтан хяналт	
Үйлчлүүлэгчийн нэр/Түүхийн дугаар		Төрсөн он, сар, өдөр	
Эмчлэгч эмчийн нэр:		Эм зүйчийн нэр:	
Илэрсэн эрсдэл	Авах арга хэмжээ (Зөвлөгөө)	Арга хэмжээ хэрэгжүүлэгч	Хэрэгжилт (Татгалзсан шалтгаан)

Эмчийн гарын үсэг Он, сар, өдөр

(Хуудсыг Эм зүйн албанд буцаан хүргүүлнэ үү?)

Эмийн эмчилгээнд хяналт хийх

Үйлчлүүлэгчдэд хэрэглэж буй эмийн концентрацийг цус, сийвэнд тодорхойлон, үйлчлүүлэгч бүрд эмийн тунг тохируулах, эмчилгээний үр нөлөөг хянах болон эмийн хордлогоос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Эмийн эмчилгээнд хяналт хийх үйл явц

- 1.1. Цус, сийвэнд эмийн концентрацийг тодорхойлох шинжилгээг эмчилгээний хүрээ бага, фармакокинетикийн хувьд хэлбэлзэл ихтэй эмүүдэд (Хүснэгт 2) тодорхойлж, эмчилгээний хяналтыг хийнэ.
- 1.2. Эмийн эмчилгээнд хяналт хийх заалт:
 - 1.2.1 Эмийн тун, тунгийн давтамжийг тохируулах;
 - 1.2.2 Эмийн эмчилгээний үр дүн эмнэл зүйтэй тохирохгүй үед шалтгааныг тодорхойлох;
 - 1.2.3 Эмийн гаж нөлөө, хордлогын шинж тэмдэг илэрсэн үед онош тогтоох;
 - 1.2.4 Эмийн хордлого болон гаж нөлөөнөөс сэргийлэхийн тулд эмийн тунгийн хязгаарыг тогтоох зорилгоор шинжилнэ.
- 1.3. Эмийн эмчилгээнд хяналт хийх зорилгоор цусанд эмийн бодисын концентрацийг тодорхойлох хүсэлтийг эмчлэгч эмч болон эм зүйч гаргана.
- 1.4. Эмийн концентрац тодорхойлох цусны дээжийг шинжилгээнд авахад эмнэлзүйн лабораторийн ажилтан болон сувилагч хамтран гүйцэтгэнэ.
- 1.5. Цусанд эмийн бодисын концентрацийг тодорхойлох хүсэлтийг эмнэлэг бүрийн онцлогт тохируулан батлагдсан маягтын дагуу (Хүснэгт 3), шинжлэх эмийн нэр, эм хэрэглэж эхэлсэн огноо, цаг, цусны дээж авах өдөр, цагийг (Хүснэгт 2) тодорхой бичсэн байна.
 - 1.5.1. Дээж авах хугацаа нь эмийн бодисын концентрацийн тогтворжсон үед буюу эмийг хэрэглэж эхэлснээс хойш хагас ялгарлын 4 үе ($t_{1/2} \times 4$) өнгөрсөн байх хугацаатай тохирсон байна.
 - 1.5.2. Эмийн тогтворжсон үеэс өөр цагт шинжилгээ авах тохиолдолд (random, through, peak) цагийг тодорхой зааж өгнө.
 - 1.5.2.1. Шууд (through) – эм хэрэглэж эхэлснээс хойш, 2 дахь тунг хэрэглэхээс өмнө шууд шинжлэх
 - 1.5.2.2. Оргил үед (peak) – эм хэрэглэж эхэлснээс хойш 1 цагийн дараа (зарим эмийн цусан дахь концентрац дээд тундаа хүрэх хугацаа өөр байна)
 - 1.5.3. Эмийн хордлогын эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмийн бодисын цусан дахь концентрац тогтворжсон үед хүрэх хугацааг

хүлээхгүйгээр ямар ч цагт санамсаргүйгээр (random) цусыг шинжилгээнд авна.

- 1.6. Цусанд эмийн бодисын концентрацийг тодорхойлох шинжилгээг эмнэлгийн Эмнэлзүйн лабораторид, мэргэшсэн мэргэжилтэн, эмийн бодисыг шинжлэх горимын дагуу шинжилнэ.
- 1.7. Эмийн эмчилгээнд хяналт хийх зорилгоор цусанд эмийн бодисын концентрацийг тодорхойлох шинжилгээний үр дүнг эмнэлзүйн эм зүйч уншиж, дүгнэлт гаргана.
- 1.8. Шинжилсэн эмийн тунг зохицуулах, эмчилгээнээс хасах, эмийн хордлогын эсрэг эмчилгээ төлөвлөх зэрэг шийдвэрийг эмчлэгч эмч болон яаралтай тусламж, эрчимт эмчилгээний мэргэшсэн эмч нар холбогдох эмчилгээний удирдамжийн дагуу гаргана.
- 1.9. Эмийн эмчилгээнд хяналт хийсэн эмийн хэрэглэж эхэлсэн цаг, шинжилсэн цаг, шинжилгээний үр дүн, эм хэрэглэсэн түүх болон эмчилгээний төлөвлөгөөнд өөрчлөлт орсноос үл хамааран бүх мэдээллийг үйлчлүүлэгчийн цахим бүртгэлийн санд заавал бүртгэнэ.
- 1.10. Эмнэлзүйн лаборатори болон Эм зүйн албанд эмийн эмчилгээнд хяналт хийсэн үйлчлүүлэгчийн мэдээллийг багтаасан “Эмийн эмчилгээнд хийсэн хяналтын мэдээний сан”-д бүртгэл (Хүснэгт 4) хөтөлнө.
- 1.11. Эмийн эмчилгээнд хяналт шаардлагатай эмийг цусанд шинжлэх урвалж бодис байхгүй тохиолдолд эрсдэл өндөртэй эмийн хяналтыг эмийн фармакологи үйлдэл, гаж нөлөө, хордлогын үед илрэх эмнэл зүйн үзүүлэлт болон шаардлагатай лаборатори, багажийн шинжилгээний аргаар хяналтыг хийнэ.

Хоёр. Эмийн эмчилгээний хяналтыг тайлагнах үйл явц

- 2.1. Эм зүйн албаны дарга “Эмийн эмчилгээний хяналтын мэдээний сан”-д дүн шинжилгээ хийж, тайланг улирал бүрийн 4 дэх долоо хоногийн Лхагва гарагт Чанар-Аюулгүй байдлын албанд хүргүүлнэ.
- 2.2. Эм зүйн албаны дарга “Эмийн эмчилгээний хяналтын мэдээний сан”-д жил бүр үнэлгээ хийж, эрсдэлтэй эмийн хэрэглээ болон эмийн эмчилгээнд хийсэн хяналт, үүссэн эрсдэл, эрсдэлээс сэргийлэх, авах арга хэмжээний талаар Чанар-Аюулгүй байдлын албанд тайлагнана.

Гурав. Эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ

- 3.1. Эмнэлгийн тасаг, алба болон нэгжүүд, харьяалагдах эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эмийн эмчилгээнд хяналт хийх шаардлагатай, эрсдэл өндөртэй эмүүдийг эмчилгээнд хэрэглэх, хянах, эрсдэлээс сэргийлэх аргуудын талаар мэдээлэл, сургалтыг Эм зүйн алба тогтмол зохион байгуулж ажиллана.
- 3.2. Эрсдэл өндөртэй эмийн хэрэглээнээс үүдэлтэй эмийн эмчилгээний алдаа, эмийн гаж тохиолдол үүссэн тохиолдолд “Эмийн эмчилгээний алдааг мэдээлэх, авах арга хэмжээ”, Эмийн гаж нөлөөг бүртгэн, мэдээлэх журам”-ыг мөрдөж ажиллана.
- 3.3. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд хохирол учирсан үед эрдлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг мөрдөн ажиллана.

Хүснэгт 1.



Тайлбар: --> Шаардлагатай тохиолдолд дахин шинжилнэ.

Хүснэгт 2.

**Цусанд эмийн бодисын концентрацийг тодорхойлох шаардлагатай
эмийн мэдээлэл**

Эмийн нэр	Дээж авахад тохиромжтой хугацаа	Эмийн дээд тунд хүрэх хугацаа (Peak)	Эмийн хагас ялгарлын хугацаа ($t_{1/2}$)	Эмийн тогтворжсон үед хүрэх хугацаа (Steady state)
Донтолт үүсгэдэг эмүүд				
Өвдөлт намдаах эмүүд				
Антибиотик				
Уналт, таталтын эсрэг эм				
Гуурсан хоолой тэлэх эм				
Зүрх судасны эм				
Дархлаа дарангуйлах эм				
Сэтгэц нөлөөт эм				

Тайлбар: * Шууд (through) – эм хэрэглэж эхэлснээс хойш, 2 дахь тунг хэрэглэхээс өмнө шууд шинжлэх

** Оргил үед (peak) – эм хэрэглэж эхэлснээс хойш 1 цагийн дараа (зарим эмийн цусан дахь концентрац дээд тундаа хүрэх хугацаа өөр байна)

Хүснэгт 3.

Цусанд эмийн бодисын концентрацийг тодорхойлох шинжилгээний хүсэлт

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ				
Нэр/картын дугаар		☐ Хэвтэн эмчлүүлэгч ☐ Амбулатори	Цус авах огноо: Он/сар/өдөр/цаг/мин	
Хүйс ☐ Эрэгтэй ☐ Эмэгтэй	Онош/шинж тэмдэг:			
HIV (+/-)	Жин (kg).	Тамхи: ☐ Үгүй Татдаг : ☐ (<10ш/хоногт) ☐ (>10ш/хоногт)		
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ ГАРГАСАН ШАЛТГААН (сонгоно уу)				
☐ тун тохирсон эсэхийг хянах ☐ гаж нөлөө илэрсэн (шинж тэмдгийг бичнэ үү?) ☐ тунг тохируулах ☐ эмчилгээний үр дүнгүй ☐ эм-эмийн харилцан нөлөөлөл ☐ барих тунг тодорхойлох ☐ бусад (бич)				
ШИНЖЛЭХ ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ				
Эмийн нэр	Эмийн хэлбэр	Хоногийн тун, давтамж	Эм эхэлсэн огноо	Сүүлийн тунгийн цаг
Хамт хэрэглэсэн эмүүдийн нэрийг бичнэ үү? (ургамлын, жоргүй олгох эмүүдийн хамт)				
Дээж хүлээн авсан огноо:		Анхааруулга: - Эмийн тун тогтвортой түвшинд хүрсэн үед шинжилнэ. - Өглөө, эм хэрэглэхээс өмнө цусыг авна.		
Дээж хүлээн авагчийн нэр:				

Хүснэгт 4.

Эмийн эмчилгээнд хийсэн хяналтын мэдээний сан

No	Нэр Өвчний түүхийн No.	Тасаг	Эмийн нэр	Огноо цаг	Дээж авсан хэлбэр	Эмийн концен -трац	Дүгнэлт
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							

Эмийн эмчилгээний алдааг бүртгэх, зохицуулах аргачлал

Үйлчлүүлэгчдэд тохиолдсон эмийн эмчилгээний алдааг бүртгэх болон авах арга хэмжээг зохицуулна.

Эмийн эмчилгээний алдаа нь жор бичих, эмийн захиалга, шошголох, савлах, түгээх, олгох, хэрэглэх аргыг сонгох, зөвлөгөө өгөх, эмчилгээг хянах болон эмийг хэрэглэх үйл ажиллагаатай холбоотой үүсэж буй аливаа тохиолдлыг хамааруулж үзнэ (Хүснэгт 1).

Нэг. Яаралтай авах арга хэмжээ

- 1.1. Эмнэлгийн мэргэжилтэн эмийг үйлчлүүлэгчид хэрэглэхээс өмнө эмийн эмчилгээний алдааг (ЭЭА) илрүүлсэн бол эмчлэгч эмчид эсвэл ажлын бус цагаар жижүүр эмчид мэдэгдэж эмчилгээний алдааг засуулна. Үйлчлүүлэгч эмийг хэрэглэсний дараа ЭЭА-г алдааг илрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн тасаг хариуцсан сувилагчид яаралтай мэдэгдэж, эмчилгээг зогсоох арга хэмжээ авна.
- 1.2. Эмнэл зүйн эм зүйч эмийн эмчилгээний алдааны эрсдэлийн зэргийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг авах ажлыг зохион байгуулна (Хүснэгт 2):
 - 1.2.1. ЭЭА-ны эрсдэлийн зэрэг 0 үед сувилагч тохирох тусламжийг удирдамжийн дагуу үзүүлнэ.
 - 1.2.2. ЭЭА-ны эрсдэлийн зэрэг 1-5 үед эмчлэгч эмч болон жижүүрийн эмчид мэдэгдэнэ.
- 1.3. ЭЭА-ны эрсдэлийн зэрэг 1-2 үед үүссэн эмнэл зүйн шинж, хүнд, хөнгөний зэргээс хамаарч шаардлагатай үзлэг, шинжилгээ хийх болон яаралтай тусламжийг эмнэл зүйн удирдамжийн дагуу эмч үзүүлнэ.
- 1.4. ЭЭА-ны эрсдэлийн зэрэг 3-5 үед Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын алба, баг журмын дагуу арга хэмжээг авна.

Хоёр. Эмийн эмчилгээний алдааг бүртгэх, үнэлэх, авах арга хэмжээ

- 2.1. Эмийн эмчилгээний алдаа, тохиолдлыг илрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн “Тохиолдол мэдээлэх хуудас”-ыг бүрэн бөглөж, тухайн тасгийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэнэ.
- 2.2. ЭЭА-ны тохиолдлыг холбогдох тасгийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн “Тасгийн тохиолдлын сан”-д бүртгээд, тасаг хариуцсан эмнэлзүйн эм зүйчид мэдэгдэнэ.

- 2.3. Эмнэл зүйн эм зүйч ЭЭА-ны тохиолдлын мэдээлэл бүрэн бөглөгдсөн эсэхийг хянаж, дутуу мэдээллийг ЭЭА мэдээлэгчээс тодруулан гүйцээх болон шаардлагатай тохиолдолд өөрийн биеэр ЭЭА-ны мэдээллийг бүртгэн авна.
- 2.4. Эмнэл зүйн эм зүйч эмчилгээний алдааны хэлбэрийг (Хүснэгт 1) тодорхойлон, ЭЭА-г Эм зүйн албаны “Эмийн эмчилгээний алдаа”-ны мэдээний санд бүртгэж, дүн шинжилгээ хийж, хэлэлцүүлэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.5. Эм зүйн албаны дарга эмийн эмчилгээний алдааны тохиолдлын санд хийсэн дүн шинжилгээний тайлан болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Эмийн эмчилгээг зохицуулах хороонд улирал бүр тайлагнана.
- 2.6. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны дарга эмийн эмчилгээний алдаа, түүнд авсан арга хэмжээг Эмнэлгийн удирдах зөвлөлд тайлагнана.
- 2.7. Эмийн эмчилгээний алдаанд авах арга хэмжээг эмнэлгийн “Тохиолдол мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам” болон “Ноцтой тохиолдол мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”-ын дагуу авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1.

Эмийн эмчилгээний алдааны хэлбэрүүд

ЭЭА-ны хэлбэрүүд	Тодорхойлолт
Жор бичилтийн алдаа (Prescribing error)	Эмийн сонголт (эм хэрэглэх заалт, эсрэг заалт, харшлын түүх, эмийн давхардал болон бусад шалтгаанаар), тун, хэлбэр, тунгийн давтамж, эм хэрэглэх аргын сонголт, шингэний концентрац, дуслын хурд, эмийн захиалга ба хэрэглэх зааварчилгаа өгөх үйл ажиллагаатай холбоотой үүссэн алдааг хэлнэ.
Эмийн захиалга орхигдсон алдаа (Omission error)	Эмчилгээнд хэрэглэх заалттай эмийн жор бичигдэхгүй орхигдох болон бичигдсэн жорын дараагийн ээлж эмийн захиалга орхигдсоноос эмчилгээ тасалдахад хүрсэн алдааг хэлнэ. Үүнд үйлчлүүлэгч эм хэрэглэхээс татгалзсан болон тодорхой үндэслэлээр эмийг эм хэрэглээгүй тохиолдлыг хамруулахгүй.
Тун хоорондын хугацааны алдаа (Wrong time error)	Эмчилгээний төлөвлөсөн хуваарь алдагдсанаас тунгийн давтамж болон хугацаа өөрчлөгдсөн алдааг хэлнэ.
Жоронд бичигдээгүй эмийн алдаа (Unauthorised drug error)	Эмчлэгч эмчийн эмчилгээнд бичигдээгүй эм хэрэглэсэн алдааг хэлнэ.
Тунгийн алдаа (Dose error)	Эмчлэгч эмчийн эмчилгээнд төлөвлөсөн эмийн тунгаас их буюу бага тунгаар эмийг олгосон, хэрэглэсэн болон тунг давтан хэрэглэсэн алдааг хэлнэ.
Эмийн хэлбэрийн алдаа (Dosage form error)	Эмчлэгч эмчийн төлөвлөсөн эмийн хэлбэрээс өөр хэлбэрээр эм хэрэглэгдсэн алдааг хэлнэ.

Эм бэлтгэх алдаа (Drug preparation error)	Эмийг буруу бэлтгэсэн болон буруу савласан алдааг хэлнэ.
Эм хэрэглэх аргын алдаа (Route of administration error)	Эмчилгээнд төлөвлөсөн эмийг буруу аргаар биед оруулсан алдааг хэлнэ.
Эм хэрэглэх техникийн алдаа (Administration technique error)	Эм хэрэглэх техник үйл ажиллагаатай холбоотой үүссэн алдааг хэлнэ.
Эмийн чанарын алдаа (Drug quality error)	эмийн физик-химийн шинж чанар алдагдсан, савлагаа гэмтсэн, буруу хадгалсан болон хүчинтэй хугацаа дууссан эм хэрэглэсэн алдааг хэлнэ.
Эмийн эмчилгээний хяналтын алдаа (Drug monitoring error)	Жор бичигдсэн эмийн дэглэмийн хяналт, эмнээс үүдэх эрсдэлийг илрүүлэх болон эмчилгээний үр нөлөөг хянах үйл ажиллагааны (эмнэл зүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээ зэрэг) алдааг хэлнэ
Эмчилгээний дэглэм мөрдөлтийн алдаа (Compliance error)	Үйлчлүүлэгчийн зүгээс эмчилгээнд төлөвлөгдсөн эмийн дэглэм мөрдөх дадал, үйлдэл төрхийн алдааг хэлнэ.

Хүснэгт 2.

Эмийн эмчилгээний алдааны эрсдэлийн түвшин

Эрсдэлийн ангилал	Эрсдэлийн түвшин	Тайлбар
Болзошгүй тохиолдол (Near miss)	0	Эм хэрэглэхээс өмнө илрүүлсэн жор бичих, эмийг захиалах, шошголох, савлах, түгээх, олгох, хэрэглэх аргыг сонгох үйл ажиллагаатай холбоотой үүссэн, үйлчлүүлэгчид хохирол учруулж болохуйц алдааны тохиолдол
	0a	Эмийн жор бичилт, захиалга, олголт орхигдсоноос эмийг хэрэглээгүй тохиолдол. Үйлчлүүлэгч сэтгэл санааны хувьд хэвийн.
	0b	Үйлчлүүлэгчид эм хэрэглэсний дараа илрүүлж, эмчилгээг зогсоосон. Эрүүл мэндэд хохирол учраагүй, үйлчлүүлэгчид бага зэрэг сэтгэл зовнил үүссэн (нэмэлт шинжилгээ, ажиглалт шаардлагагүй).
Тохиолдол (Incident)	1a	Үйлчлүүлэгчид эм хэрэглэсний дараа илрүүлж, эмчилгээг зогсоосон. Эрүүл мэндэд хохирол учруулаагүй боловч нэмэлт шинжилгээ, ажиглалт шаардагдсан, сэргийлэх арга хэмжээ авсан. Үйлчлүүлэгчид бага зэрэг сэтгэл зовнил үүссэн.
	1b (Хөнгөн)	Үйлчлүүлэгчид эм хэрэглэсний дараа илрүүлж, эмчилгээг зогсоосон. Эрүүл мэндэд түр зуурын хохирол үүсгэсэн, хөнгөн эмчилгээ шаардагдсан
	2	Үйлчлүүлэгчид эм хэрэглэсний дараа илрүүлж, эмчилгээг зогсоосон. Эрүүл мэндэд түр зуурын хохирол үүсгэсэн,

	(Дунд)	эмчилгээ хийсэн, шаардлагатай үед яаралтай тусламжийн эмчилгээ шаардагдсан
Ноцтой тохиолдол (Accident)	3 (Хүнд)	Эрчимт эмчилгээ шаардлагатай. Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтэд илэрхий өөрчлөлт гарсан.
	4 (Маш хүнд)	Урт хугацааны эрчимт эмчилгээ шаардлагатай. Амьдралын хугацааг уртасгах арга хэмжээ (амьсгал, зүрх судасны үйл ажиллагаа дэмжих төхөөрөмж, дефибрилляц, интубац) авахад хүргэсэн. Байнгын хөгжлийн бэрхшээл үүсгэж болзошгүй.
	5	Нас барсан

Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, зохицуулах аргачлал

Үйлчлүүлэгчдэд тохиолдсон эмийн гаж нөлөөг бүртгэх, үнэлэх, мэдээлэх болон авах арга хэмжээг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу зохицуулна.

Нэг. Яаралтай авах арга хэмжээ

- 1.1. Эмчилгээний явцад эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд сувилагч нэн даруй эмийн хэрэглээг зогсоож, эмчлэгч эмч болон жижүүрийн эмчид мэдэгдэнэ.
- 1.2. Эмч гаж нөлөөний хэлбэр, эмнэлзүйн шинж тэмдгээс хамаарч, хүнд хөнгөний зэргийг үнэлнэ:
 - 1.2.1. 1-5 түвшингийн гаж нөлөө илэрсэн үед эмчилгээг эмнэл зүйн удирдамжийн дагуу, тухайн тасагт шийдвэрлэнэ.
 - 1.2.2. 6 түвшингийн гаж нөлөө илэрсэн үед “Шуурхай үйлдлийн баг идэвхжүүлэх журам”-ын дагуу шаардлагатай тусламжийг шийдвэрлэнэ.
 - 1.2.3. 7 түвшингийн гаж нөлөө илэрсэн үед “Код бло багийг идэвхжүүлэх” журам”-ын дагуу арга хэмжээг зохион байгуулна.
- 1.3. Гаж нөлөөний тохиолдол бүрд тухайн гаж нөлөөний эмнэл зүйн илрэл, эмчилгээний арга хэмжээ, эмчилгээний үр дүнг тусламж үзүүлсэн эмч үйлчлүүлэгчийн цахим бүртгэл болон өвчний түүхэнд тэмдэглэж, баримтжуулна.

Хоёр. Эмнэлэгт эмийн гаж нөлөөг бүртгэх, үнэлэх

- 2.1. Эмнэлгийн тасаг, нэгжид болон амбулаториор үйлчлүүлэгчдэд илэрсэн эмийн гаж нөлөөний тохиолдлыг илрүүлсэн эмнэлгийн бүх мэргэжилтэн (эмч, резидент, сувилагч, эм зүйч) эмийн гаж нөлөөний мэдээллийг үндэсний мэдээний сан (Vigiflow)-д цахимаар эсвэл ЭЭХХЗГ-ын цахим хуудсанд (www.mmra.gov.mn) байршуулсан 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу шивж ЭЭХХЗГ-ын gajinoloo@mmra.gov.mn хаяг руу имэйлээр илгээнэ.
- 2.2. Эмнэлгийн тасаг, нэгжид болон амбулаториор үйлчлүүлэгчдэд илэрсэн эмийн гаж нөлөөний тохиолдлыг гаж нөлөөний тохиолдол илэрсэн үед сувилагч гаж нөлөөний мэдээлэх хуудсыг бөглөж, тасаг хариуцсан эмнэл зүйн эм зүйчид мэдэгдэнэ.
- 2.3. Тасаг хариуцсан эмнэл зүйн эм зүйч гаж нөлөөний мэдээллийг шалгаж, гаж нөлөөг мэдээлэх хуудсанд анхан шатны үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд мэдээлэгчтэй холбоо барьж, дутуу мэдээллүүдийг нөхөн бөглөнө.
- 2.4. Эм зүйн албаны эмийн аюулгүй байдал хариуцсан эм зүйч гаж нөлөөний мэдээлэлд Наранжогийн горимыг (Хүснэгт 1) ашиглан үнэлнэ:
 - 2.4.1. 1-4-р түвшингийн гаж нөлөөний тохиолдлыг Эм зүйн алба болон тасгийн хүрээнд асуудлыг шийдвэрлэнэ.

- 2.4.2. 5-7 түвшингийн гаж нөлөөний тохиолдлыг Эмийн эмчилгээг зохицуулах хороонд яаралтай мэдэгдэнэ.

Гурав. Гаж нөлөөний тохиолдлыг эргэн мэдээлэх, тайлагнах

- 3.1. Эм зүйн албаны эмийн аюулгүй байдал хариуцсан эм зүйч “Эмийн гаж нөлөөний тохиолдлын сан”-д дүн шинжилгээ хийж, тайланг гаргана.
- 3.2. Эмнэлэгт эмийн гаж нөлөө аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн нь сар бүр эмнэлэгт бүртгэн, мэдээлсэн гаж нөлөөний тохиолдлыг тасаг нэгжээс нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Эмийн эмчилгээг зохицуулах хороо эсвэл Эмнэлгийн удирдлагад тайлагнана.
- 3.3. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны дарга “Эмийн гаж нөлөөний тохиолдлын сан”-гийн тайланг Эмнэлгийн удирдах зөвлөлд тайлагнана.
- 3.4. Эм зүйн албаны дарга эмнэлгийн “Эмийн гаж нөлөөний тохиолдлын сан”-гийн тайлан болон ЭМЯ-ны Хүний эмийн зөвлөл, ЭЭХХЗГ-аас гаж нөлөөний мэдээллийн дагуу ирүүлсэн зөвлөмж, анхааруулгыг тухай бүрд эмнэлгийн нийт мэргэжилтнүүдэд цахим болон эмнэлгийн нэгдсэн хурлаар эргэн мэдээлэл хийнэ.
- 3.5. Эмийн гаж нөлөө аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн нь мэдээлэх шаардлагатай гаж нөлөөний тохиолдлыг харилцагч Эм хангамжийн байгууллагад мэдэгдэнэ.

Дөрөв. Эмийн гаж нөлөөнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах

- 4.1. Эм зүйн алба улирал бүр эмнэлгийн мэргэжилтнүүд болон үйлчлүүлэгчдэд эмийн гаж нөлөө, түүнээс сэргийлэх арга замын талаар мэдээлэл, сургалт явуулна.
- 4.2. Эмнэлгийн тасаг, алба болон нэгжүүд урьдчилан сэргийлэх боломжтой гаж нөлөөний тохиолдлыг дахин үүсгэхгүй, урьдчилан сэргийлэхийн тулд “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг мөрдөн ажиллана.

Хүснэгт 1.

Эмийн гаж нөлөөг үнэлэх Наранжогийн горим

Асуулт	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Энэхүү эмийн гаж нөлөөний талаар урьд өмнө нь мэдээлсэн баримт бий юу?	+1	0	0
2. Эм хэрэглэсний дараа сэжигтэй гаж тохиолдол илэрсэн үү?	+2	-1	0
3. Эмийг зогсоосон эсвэл өвөрмөц антагонист хэрэглэсний дараа гаж нөлөө арилсан уу?	+1	0	0
4. Эмийг дахин хэрэглэхэд гаж нөлөө дахин үүссэн үү?	+2	-1	0
5. Гаж нөлөө үүсэхэд нөлөөлсөн байж болох бусад шалтгаан (бусад өөр эм) бий юу?	-1	+2	0
6. Плацебо эм өгөхөд гаж нөлөө дахин илэрсэн үү?	-1	+1	0
7. Цус болон бусад шингэнд хордуулах тунгаар эм илэрсэн үү?	+1	0	0
8. Эмийн тунг нэмэгдүүлэхэд гаж нөлөө улам хүндэрч эсвэл эмийн тунг бууруулахад намжиж байсан уу?	+1	0	0
9. Уг эмийг болон нэг бүлгийн эмийг хэрэглэхэд урьд өмнө нь ижил нөлөө үүсэж байсан уу?	+1	0	0
10. Гаж нөлөө ямар нэг бодит нотолгоогоор батлагдсан уу?	+1	0	0

Үнэлгээ:

≥ 9 илэрхий

5-8 үнэмшилтэй

1-4 байж болох

0- шалтгаан хамааралгүй гэж дүгнэнэ.

Тайлбар: 6-р асуулт эмнэл зүйн судалгаа явуулж буй үед илэрсэн гаж нөлөөг үнэлэхэд хэрэгл

Эрүүл мэндийн сайдын
оны.....сарын.....-ны өдрийн
.....дугаар тушаалын 6 дугаар хавсралт

Эмнэлгийн эмийн лавлахыг зохицуулах заавар

Эмчилгээнд хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай, өргөн хэрэглэгддэг, эмчилгээний үр нөлөө сайтай, аюулгүй эмийг сонгож, “Эмнэлгийн эмийн жагсаалт” боловсруулах, жагсаалтын эмийг хянах үйл ажиллагааг зохицуулна.

Эмнэлгийн эмийн лавлах боловсруулж, мөрдөж ажилласнаар “лавлахын бус” эмийн хэрэглээг багасгаж, эмийн хяналтгүй хэрэгцээг хязгаарлах замаар эмийн аюулгүй байдал, эмчилгээний үр нөлөөг сайжруулахын зэрэгцээ эмнэлгийн эмийн зардлыг хянах, эдийн засгийн хувьд үр ашигтай байх боломжийг бүрдүүлнэ.

Нэг. Эмнэлгийн эмийн жагсаалт боловсруулах үйл ажиллагаа

- 1.1. Эмнэлэгт үйлчлүүлэгчдийн оношилгоо, эмчилгээнд “Эмнэлгийн эмийн лавлах”-ын эмийг хэрэглэнэ.
- 1.2. Эмнэлгийн тасаг, нэгжийн оношилгоо, эмчилгээнд хэрэглэх эмийн жагсаалтын саналыг тухайн тасаг нэгж хэлэлцэн баталж, саналыг жил бүр 10 дугаар сарын 15-ны дотор Эм зүйн албанд хүргүүлнэ.
- 1.3. Эмнэлгийн тасаг, нэгжээс ирүүлсэн эмийн жагсаалтын саналыг Эм зүйн алба нэгтгэн, эмийн жагсаалтын төслийг боловсруулах ба шаардлагатай тохиолдолд санал оруулсан тасаг нэгжээс холбогдох удирдамж, судалгааны нотолгоо зэргийг шаардана.
- 1.4. Эмнэлэгт хэрэглэх эмийн жагсаалтын төслийг дараах судалгаа, нотолгоонд тулгуурлан боловсруулна:
 - 1.4.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл, өвчлөл, үйлчлүүлэгчийн статистик үзүүлэлт
 - 1.4.2. Эмнэлгийн эмийн хэрэглээний судалгаа
 - 1.4.3. Өвчний оношилгоо-эмчилгээний удирдамж
 - 1.4.4. Эмнэлзүй, эмийн эмчилгээний чиглэлээр хийсэн нотолгоонд суурилсан судалгаа
 - 1.4.5. Эмийн аюулгүй байдлын судалгаа
 - 1.4.6. Эмийн эдийн засаг, өтрөг зардлын судалгаа
- 1.5. Эмнэлгийн эмийн жагсаалтад оруулах эмийн сонголтод дараах шалгуур үзүүлэлтэд тулгуурлана:
 - 1.5.1. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн
 - 1.5.2. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон
 - 1.5.3. Бренд эмийг орлуулах женерик эмийн сонголттой
 - 1.5.4. Эмийн эмчилгээний үр нөлөө нь үнэ өртгөөс давуу болох нь нотлогдсон
- 1.6. Эмийн жагсаалтын төслийг Эмийн эмчилгээг зохицуулах (ЭЭЗХ) хороо хэлэлцэн, “Эмнэлгийн эмийн лавлах”-ыг батална.

- 1.7. Эмнэлэгт хэрэглэх “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмийн жагсаалт”, “Өндөр эрсдэлт эмийн жагсаалт”-ыг Эмнэлгийн эмийн жагсаалтын тусгай бүлгээр батална.

**Хоёр. Эмнэлгийн эмийн лавлахад эм нэмж бүртгүүлэх үйл ажиллагаа,
шийдвэрлэх үйл ажиллагаа**

- 2.1. Эмнэлгийн эмийн лавлах шинэчлэх хугацаанаас өмнө лавлахын бус эмийг эмчилгээ, оношилгоонд байнга хэрэглэх шаардлага гарсан тохиолдолд тухайн эмийг хэрэглэх тасаг нэгж жагсаалтад нэмж оруулах үндэслэл хэлэлцэн, хурлын тэмдэглэлээр баталгаажуулна.
- 2.2. “Эмнэлгийн эмийн лавлах”-д эм нэмж бүртгүүлэх саналтай тасаг нэгж, хүсэлтийн маягтыг (Хүснэгт 1) бөглөн, тасгийн хурлын тэмдэглэлийн хамт ЭЭЗХ-ний нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 2.3. ЭЭЗХ-ний нарийн бичгийн дарга хүсэлтийн дагуу эмийн мэдээллийг судлан, эмийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж, ЭЭЗХ-ны хурлаар хэлэлцүүлэн, “Түр хугацааны эм”-ээр бүртгэж, эмнэлэгт түр хэрэглэх хугацааг шийдвэрлэнэ.
- 2.4. Эмнэл зүйн эм зүйч “түр хугацааны эм”-ийн эмчилгээний үр нөлөө, жор бичилт, гаж нөлөө, аюулгүй байдалд идэвхтэй тандалт судалгаа явуулж, үр дүнг ЭЭЗХ-ноос шийдвэрлэсэн хугацаанд багтаан танилцуулна.
- 2.5. “Түр хугацааны эм”-ээр бүртгэгдсэн эмийг эмнэлэгт хэрэглэх үед эмийн аюулгүй байдалтай холбоотой илэрсэн тохиолдлыг “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”, “Эмийн эмчилгээний алдааг бүртгэн мэдээлэх журам”-ын дагуу зохицуулна.
- 2.6. ЭЭЗХ нь түр хугацааны эмийг эмнэлгийн эмийн жагсаалтад оруулах асуудлыг тухайн эмийн бүртгэлийн байдал, аюулгүй байдал, эмчилгээний үр нөлөө, хэрэглээ, хангамж, үнэ зэрэг нотолгоонд суурилж шийдвэр гаргана.
- 2.7. Эмнэлгийн эмийн лавлахад бүртгэгдэхээр шийдвэр гаргах тохиолдолд эмнэлгийн ЭЭЗХ ба Санхүү, нягтлан бодох, бүртгэлийн алба хамтарсан шийдвэр гарган, баталгаажуулна.
- 2.8. ЭЭЗХ-ны хурлаас гарсан шийдвэрийг тухайн тасаг нэгжид ажлын 5 хоногт багтаан эргэн мэдээлнэ.
- 2.9. “Түр хугацааны эм”-ээр бүртгэгдсэн эмийн аюулгүй байдалтай холбоотой асуудал илэрсэн тохиолдолд ЭЭЗХ хуралдан, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 2.10. Эм зүйн албаны нөөцийн тасгийн эм зүйч эмнэлгийн эмийн жагсаалтад шинээр бүртгэгдэхээр шийдэгдсэн эмийг ханган нийлүүлэх байгууллагыг сонгох, худалдан авахтай холбоотой бэлтгэл ажил, бичиг баримт бүрдүүлэх ажлыг 14 хоног хүртэл хугацаанд багтааж хийнэ.
- 2.11. Эм зүйн албаны дарга эмнэлгийн эмийн жагсаалтад шинээр бүртгэгдсэн эмийг худалдан авах, хангах үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХБАҮХА) болон Эм худалдан авах, хүлээн авах журмын дагуу зохион байгуулна.

Гурав. Эмнэлгийн эмийн лавлах боловсруулах

- 3.1. ЭЭЗХ-ноос баталсан эмийн жагсаалтад багтсан эмийн товч мэдээллийг багтаасан “Эмнэлгийн эмийн лавлах” боловсруулах ажлыг Эм зүйн алба хариуцана.

- 3.2. ЭЭЗХ нь “Эмнэлгийн эмийн лавлах” эмнэлгийн мэргэжилтнүүдийн хэрэгцээнд нээлттэй ил тод байлгах ажлыг хариуцан ажиллана.
- 3.3. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээнд “Эмнэлгийн эмийн лавлах”-д багтсан эмээр үйлчлэх, эмийн хэрэглээ болон аюулгүй байдалд хяналт, судалгаа хийх ажлыг Эм зүйн алба хариуцан ажиллаж, жил бүр тайлагнаж байна.

Дөрөв. “Эмнэлгийн эмийн лавлах”-ын эмийн хэрэглээг хянах, зохицуулах

- 4.1. Эмч лавлахын бус эмийн жор бичих шаардлага гарсан тохиолдолд тасаг хариуцсан эмнэлзүйн эм зүйчтэй зөвлөж, заалтыг танилцуулан, захиалгыг хийнэ.
- 4.2. Эм зүйн алба нь лавлахын бус эмийн ханган нийлүүлэлт, эмчилгээ эхлэх хугацааны талаар эмчид мэдээлнэ.
- 4.3. Эм зүйн алба лавлахын эмийн хэрэглээний судалгааг тогтмол хийж, судалгааны дүнг ЭЭЗХ-д жил бүрийн 11 сарын эхний 7 хоногт багтаан тайлагнана.
- 4.4. ЭЭЗХ нь “Эмнэлгийн эмийн лавлах” болон түүнд орох нэмэлт өөрчлөлтийг жилийн бүрийн 11 сарын эхний долоо хоногт багтаан хэлэлцэж батална.
- 4.5. Эм зүйн алба эмнэлгийн эмийн лавлах, лавлахын эмийн мэдээллийн өөрчлөлтийг цаг тухайд нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд цахим болон сургалтаар мэдээлнэ.

Эм тасарсан үед авах арга хэмжээ

Эмийн төв агуулах, нөөцийн тасагт эм тасарсан үед авах арга хэмжээ, эмийн эмчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Эмийн тасалдлыг тодорхойлох, авах арга хэмжээ

- 1.1 Эм зүйн албаны дарга эмийн зах зээлийн байдалд дүн шинжилгээ хийж, эмийн хангамж, нийлүүлэлтийн талаар, тасрах магадлалтай, олдоц ховор эмийн мэдээллийг цуглуулан, эмийн тасалдал үүсэх үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллана.
- 1.2 Жор баригч эм зүйчид эмийн төв агуулах, нөөцийн тасгийн эм, бэлдмэлийн сар бүрийн тооллогод үндэслэн тасрах магадлалтай байгаа эмийн жагсаалтыг сар бүр гарган, Эм зүйн албаны даргад мэдэгдэнэ.
- 1.3 Эм зүйн алба эмийн агуулахын хүрээнд эмийн тасалдлын байдлыг сар бүр хэлэлцэн, эм тасрах шалтгаан нөхцөлийн талаар дүн шинжилгээ хийж, тасалдлаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 1.4 Эм, бэлдмэлийн найдвартай нөөцийн хэмжээ нь эм зүйн албаны агуулахад 0 болох үед эмийн тасалдал үүссэн гэж үзнэ.
- 1.5 Эм тасарсан үед “Тасарсан эмийн бүртгэл” (Хүснэгт 1) хөтөлж, бүртгэлийн мэдээллийг эмийн хэрэгцээг тооцоход ашиглана.
- 1.6 Эм зүйн албаны дарга, жор баригч эм зүйчид эм тасалдсан шалтгаан нөхцөлийг тодорхойлон авах арга хэмжээг зохион байгуулна:
 - 1.6.1 Эм улсын хэмжээнд тасарсан тохиолдолд орлуулж болохуйц эмийн жагсаалтыг гарган “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-ны хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.
 - 1.6.2 Нийлүүлэгч байгууллагын хэмжээнд тасарсан бол өөр Эм ханган нийлүүлэгч байгууллагатай гэрээ хийх, эмийг ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Эмийн тасалдлыг бүртгэх, мэдээлэх

- 2.1. Эмийн тасалдлын бүртгэлийг эмийн агуулах, нөөцийн тасгийн эм зүйч хөтлөх ба эмийн санд тавигдах нийтлэг шаардлагыг мөрдлөг болгоно (Хүснэгт 1).
- 2.2. Эмийн төв агуулах хариуцсан эм зүйч Эм ханган нийлүүлэх байгууллагатай хийсэн худалдан авах гэрээ, төлөвлөгөө, графикийн дагуу эмийн хангалтын гүйцэтгэл, үр дүнг хянаж, тасарсан эмийн мэдээллийг цуглуулна.
- 2.3. Нөөцийн тасгийн эм зүйч нь тасарсан эм болон орлуулж болохуйц эмийн жагсаалтыг гаргаж, эм зүйн албаны дарга, эмнэлзүйн эм зүйчид мэдэгдэнэ.
- 2.4. Эм тасарсан тухай бүр Эм зүйн албаны дарга “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-нд танилцуулж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.5. Эмнэлзүйн эм зүйчид хариуцсан тасгийн эмч, сувилагч нарт “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-ны шийдвэр, эмийн тасалдлын тухай болон орлуулж болохуйц эмийн талаар мэдээлнэ.

2.6. Эм зүйн албаны дарга тасарсан эмийг эмнэлгийн цахим мэдээллийн системд бүртгүүлнэ.

Хүснэгт 1.

Эмийн санд тавих нийтлэг
шаардлага MNS 5260:2015

Тасарсан эмийн бүртгэл

Эмийн сангийн нэр он сар

д/д	Он сар өдөр	Тасарсан эмийн нэр, тун хэмжээ	Хэмжих нэгж	Олгогдоогүй эмийн тоо	Эм нийлүүлэгдэж эхэлсэн /олгож эхэлсэн/ сар өдөр	Нийлүүлэгдсэн эмийн тоо хэмжээ	$C_1(\text{сар})$ + тасарсан хугацаанд олгогдох байсан эмийн тоо + нийлүүлэгдэж олгогдсон эмийн тоо = тухайн сард нийт олгогдсон буюу зарцуулсан эмийн тоо	Бүртгэсэн мэргэжилтний нэр, гарын үсэг

Тайлбар: Энэхүү бүртгэл нь эмийн сангийн үйлчилгээг болон эмийн хэрэгцээг тооцох үндэслэл болж өгнө

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн эргүүлэн татах эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаа

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанар, аюулгүй байдлын улмаас үүссэн ноцтой тохиолдол мэдээлэгдсэн, хуурамч байх эргэлзээтэй болон стандартын бус бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд тухайн бүтээгдэхүүний түгээлтийг хориглох, эргүүлэн татах үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу зохицуулна.

Нэг. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн эргүүлэн татах үйл ажиллагаа

- 1.1. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанар, аюулгүй байдалтай холбоотой илэрсэн тохиолдлыг илрүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн “Тохиолдол мэдээлэх хуудас” бөглөн “Тохиолдол мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”-ын дагуу мэдээлнэ.
- 1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албанд мэдээлэгдсэн эм, бэлдмэлийн чанар, аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бүрийг Эм зүйн албанд ажлын 2 цагийн дотор яаралтай мэдээлнэ.
- 1.3. ЭЭЗХ-с гарсан шийдвэрийн дагуу Эм зүйн албаны дарга эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг эргүүлэн татах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.4. Эм зүйн албаны дарга Эм эргүүлэн татсан шийдвэр, шинжилгээний дүгнэлт, бүтээгдэхүүний мэдээлэл, орлого зарлагын тайланг чанарын албанд танилцуулж, баталгаажуулна.
- 1.5. Эргүүлэн татаж, буцаасан, устгасан эм, эмийн бүтээгдэхүүнийг Эм зүйн албаны мэдээний санд бүртгэл хөтөлнө
- 1.6. Эм зүйн албаны дарга эргүүлэн татсан, устгасан эм, эмийн бүтээгдэхүүний мэдээллийн тайлан, эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын зөвлөлд танилцуулна.
- 1.7. Эм зүйн албаны дарга эргүүлэн татсан, устгасан эм, эмийн бүтээгдэхүүний эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж ажиллана.
- 1.8. Эм зүйн алба эм, эмийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын улмаас үүссэн ноцтой тохиолдлыг мэдээлэх, хуурамч болон стандартын бус бүтээгдэхүүнийг таних, илрүүлэх сургалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулах ажлыг хариуцна.
- 1.9. Эм, эмийн бүтээгдэхүүн эргүүлэн татах тогтолцооны бэлэн байдал, үйл ажиллагааны урсгалыг шалгах зорилгоор “эргүүлэн таталт” хийх дадлага сургуулилтыг жилд 1 удаа хийнэ.

Эм хадгалах, агуулах үйл ажиллагаа

Эмийн төв агуулах, нөөцийн тасаг болон тасгийн эмийн нөөцийн шүүгээнд эм, бэлдмэлийг хадгалах үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Эмийг агуулахад хадгалах

- 1.1. Эмнэлэгт хэрэглэх эмийн нөөцийг “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015” стандарт нийцсэн агуулахад хадгална.
- 1.2. Эмийн төв агуулах болон нөөцийн өрөөнд эм, бэлдмэлийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах шаардлагыг хангасан төхөөрөмж болон хүрэлцэхүйц хэмжээний зориулалтын тавиурыг стандартын дагуу байрлуулж, эмийг хадгална.
- 1.3. Эмийн физик, химийн шинж чанартай нь уялдуулан тэдгээрийг үйлдвэрлэгчийн заасан температур, чийглэгийг хангасан нөхцөлд хадгална. Үүнд:
 - 1.3.1. “Хүйтэн нөхцөлд” гэж заасан бол хөргөгчид $2^{\circ}\text{--}8^{\circ}\text{C}$ -д
 - 1.3.2. “Сэрүүн нөхцөлд” бол $8^{\circ}\text{--}15^{\circ}\text{C}$
 - 1.3.3. “Тасалгааны температурт” бол $15^{\circ}\text{--}25^{\circ}\text{C}$ -д
 - 1.3.4. Вакциныг хүйтэн хэлхээний зарчмыг баримтлан хадгална.
 - 1.3.5. Агуулахын харьцангуй чийглэг нь 20%-60% байна
- 1.4. Шатамхай бодисыг агааржуулалт сайтай, нарны гэрэл шууд тусдаггүй, сэрүүн, галд тэсвэртэй газар хадгална.
- 1.5. Гэрэлд мэдрэг эмийг харанхуй орчинд хадгална.
- 1.6. Амьтны гаралтай бэлдмэлийг хуурай, сэрүүн, гэрлээс хамгаалсан нөхцөлд $0^{\circ}\text{--}15^{\circ}\text{C}$ -д тусгайлан заалт байхгүй тохиолдолд хадгална.
- 1.7. Тосон түрхлэгийг зааварт заасны дагуу хүйтэн эсвэл сэрүүн нөхцөлд хадгална.
- 1.8. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг журмын дагуу цоожтой зориулалтын төмөр шүүгээнд, камержуулсан хэсэгт хадгалж, бүртгэл хөтөлнө.
- 1.9. Галд тэсрэмтгий, ууршимтгай шингэн эмүүдийг төмрөөр доторлосон шүүгээнд, шилэн саванд хийж гадны нөлөөлөл, гал, усны аюулаас хамгаалсан нөхцөлд хадгална.
- 1.10. Эмийн агуулах, нөөцийн өрөөнд тавиур, шүүгээ, хөргөгчид эмийг эм судлалын бүлэг, хэлбэрээр ангилсан тусгай тавцанд, хадгалалтын горимын дагуу байрлуулна.
- 1.11. Тавцанд эмийг өрж байрлуулахад эмийг олох, авахад хялбар байхаар зохион байгуулж, эмийн Олон улсын нэршлээр хаягжуулна.
- 1.12. Тавцанд эхэлж ирснийг эхэлж гаргах (First in, First out), эхэлж хугацаа дуусах эмийг эхэлж гаргах (First expire, First out) зарчмаар эмийг байрлуулна.
- 1.13. Хэрэглэх хугацаа дууссан, чанар байдал нь өөрчлөгдсөн болон стандартын бус бүтээгдэхүүн, эргүүлэн татсан эм барааг буцаах, устгах хүртэл баримтжуулан, тусгайлан хадгална.

Хоёр. Эм хадгалалтад хяналт тавих

- 2.1. Эмийн агуулах, нөөцийн өрөөнүүдийг камержуулж, Эмнэлгийн хамгаалалтын албаны байнгын хяналтад байна.
- 2.2. Эмийн агуулах, нөөцийн өрөөнүүдэд зөвхөн хариуцсан эм зүйчид орж ажиллана.
- 2.3. Шаардлагатай тохиолдолд харуул хамгаалалтын алба болон бусад эмнэлгийн мэргэжилтэн орж ажиллах үед урьдчилж Эм зүйн албаны дарга, хариуцсан эм зүйчид мэдэгдэн, тэдгээрийг байлцуулан ажил, үйлчилгээ явуулна.
- 2.4. Эмийн агуулах, нөөцийн өрөөнүүдэд эмийг хэлбэрээр, эм судлалын бүлгээр ангилж, хадгалалтын горимын дагуу эмийн нэр, тун, цуврал, хугацааг бичсэн хөдөлгөөнт хуудас хөтөлж, хүчинтэй хугацааг байнга хянана.
- 2.5. Эмийн агуулах, нөөцийн тасгийн эм зүйч хариуцсан нэгжид агуулж буй эм, бэлдмэлийн хугацаанд эмийн самбар, хуудсыг өдөр бүр хянаж, эмийг хүчинтэй хугацаанд олгох, түгээх асуудлыг хариуцаж ажиллана.
- 2.6. Эм зүйн албаны дарга эмнэлэгт хэрэглэж буй эмийн хэрэгцээ, зарцуулалтыг тогтмол хянаж, үлдэгдэл ихтэй эмийг хүчинтэй хугацаа дуусахаас өмнө Эм ханган нийлүүлэх байгууллагатай хийсэн гэрээний дагуу эмийг буцаах, солих, татан авалтын графикт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна.
- 2.7. Эмийн агуулахын эм зүйч хугацаа дууссан эмийг хүрэн өнгийн уутанд цуглуулан, Эмнэлгийн хог хаягдлын гэрээт компанитай хийсэн гэрээний устгалд оруулна.
- 2.8. Эмийн агуулах, нөөцийн өрөөний чийгшил, температурыг нөөцийн тасаг хариуцсан эм зүйч эсвэл эм найруулагч өдөрт 2 удаа шалгаж тэмдэглэл хөтлөх ба эм зүйч долоо хоног бүр тэмдэглэлийг хянана. (Хүснэгт 1).
- 2.9. Эмийн агуулах, нөөцийн тасгийн эм зүйч хариуцсан нэгжийн эм, бэлдмэлийн хадгалалт, хяналтын тайланг сар бүр нэгтгэн баримтжуулж, эм зүйн албаны даргад мэдээлнэ.
- 2.10. Эмийн агуулах, нөөцийн тасагт агуулж буй эм, бэлдмэлийн тооллогыг “Эм зүйн албаны тооллого хийх стандарт үйл ажиллагааны заавар” -ын дагуу хийнэ.
- 2.11. Эмийн агуулах, нөөцийн тасаг, эмийн сангийн өрөөнд чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр, их цэвэрлэгээг долоо хоногт 1 удаа тогтмол хийж тэмдэглэл хөтөлнө.

Гурав. Тасаг, нэгжийн эмийн нөөцийн шүүгээний эм хадгалалтад хяналт тавих

- 3.1. Эмнэлгийн тасаг нэгжид байрлах эмийн нөөцийн шүүгээнд хадгалах эмийг эм судлалын бүлэг болон эмийн хэлбэрээр ангилж, хаягжуулж дуусах хугацааг тавьж хадгална.
- 3.2. Тасгийн эмийн нөөцийн шүүгээнд эмийг эхэлж ирснийг эхэлж гаргах (First in, First out), эхэлж хугацаа дуусах эмийг эхэлж гаргах (First expire, First out) зарчмаар эмийг байрлуулна.
- 3.3. Өндөр эрсдэлт эмийг шүүгээний нэг эгнээнд байрлуулж “Өндөр эрсдэлт эм” гэсэн шошго нааж хаягжуулна.
- 3.4. Эм, бэлдмэл хадгалж буй нөөцийн шүүгээ, хөргөгчид термометр, чийг хэмжигчийг байрлуулж, тасгийн ээлжийн сувилагч заалтыг өдөр тутам хянаж, тэмдэглэл хөтөлнө (Хүснэгт 1).
- 3.5. Тасаг хариуцсан ахлах сувилагч Яаралтай тусламжийн эмийн шүүгээн дэх эмийн хугацааг хөтөлнө.
- 3.6. “Тасгийн эмийн нөөцийн шүүгээ”-нд байрлах эм, бэлдмэлийн хүчинтэй хугацаанд тухайн тасгийн хариуцсан сувилагч хяналт тавьж, хугацаа дуусахаас 2 сарын

- өмнө эм зүйн албанд буцааж, Эмийн орлого, зарлагын дэвтэрт тэмдэглэн баримтжуулна.
- 3.7. Хугацаа дуусахаас өмнө буцаагаагүй тохиолдолд эм, бэлдмэл хариуцаж байсан тасаг нэгж хариуцлага хүлээнэ.
- 3.8. Тасгийн эмийн нөөцийн шүүгээг тухайн тасаг хариуцсан эмнэлзүйн эм зүйч сард нэг удаа “Эмийн нөөцийн шүүгээний хяналтын хуудас”-аар хянаж, эмийн орлого, зарлагын дэвтэр, чийг, температурын хяналтын хуудас, эмийн хадгалалт, хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай заавар, зөвлөгөө өгнө. (Хүснэгт 2).

ЭМИЙН НӨӨЦИЙН ШҮҮГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Тасгийн нэр:		Огноо:	Тийм	Үгүй
1	Эмийн нөөцийн шүүгээ, эмх цэгцтэй, цэвэрхэн		1	0
2	Тарилгын, ариун эмүүдийг бусад эмээс тусгаарлаж, байршуулсан		1	0
3	Шошгогүй болон буруу шошготой эм байхгүй		1	0
4	Шүүгээний жагсаалтад ороогүй эм хадгалаагүй		1	0
5	Эмийн батлагдсан тооноос илүү эм байхгүй		1	0
6	Хугацаа дууссан эм байхгүй		1	0
7	Хөргөгчийн t ⁰ тогтмол хэмжээнд, бүртгэл хөтөлсөн		1	0
8	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмийг зөв хадгалсан, бүртгэл хөтөлсөн		1	0
9	Яаралтай тусламжийн эмүүд бүрэн хангагдсан		1	0
10	Найруулсан, шингэлж бэлдсэн дуслын концентрац, огноо, цаг тэмдэглэсэн		1	0
11	Шүүгээний эмийн орлого, зарлагын дэвтэр бүрэн, зөв хөтөлсөн		1	0
12	Нөөцийн шүүгээний эмийн хадгалалт, хамгаалалтын хяналт сайн		1	0
НИЙТ ОНОО (12)				
Тэмдэглэл, тайлбар:				
Хяналтын дүнд өгсөн зөвлөмж:				

Хянасан эм зүйчийн гарын үсэг: /..... /

Тасгийн ахлах сувилагчийн гарын үсэг: /..... /

Хүснэгт 1.

**Нөөцийн өрөөний болон эгзэгтэй цэгийн термометр, чийг
хэмжигчийн тэмдэглэл**

№	Огноо			Нөөцийн өрөөний нэр:			Эгзэгтэй цэг:	
	Он	Сар	Өдөр	Термометрийн заалт	Чийг хэмжигчийн заалт	Тэмдэглэл хөтөлсөн	Термометрийн заалт	Чийг хэмжигчийн заалт
<u>1</u>								
<u>2</u>								
<u>3</u>								
<u>4</u>								
<u>5</u>								
<u>6</u>								
<u>7</u>								
<u>8</u>								
<u>9</u>								
<u>10</u>								
<u>11</u>								
<u>12</u>								
<u>13</u>								
<u>14</u>								
<u>15</u>								
<u>16</u>								
<u>17</u>								

Эмийн мэдээлэл хийх үйл ажиллагаа

Эм зүйн албанаас эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчдэд эмийн мэдээлэл хийх үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмийн мэдээлэл хийх

- 1.1. Эм зүйн алба эмнэлэгт хэрэглэсэн эмийн хэрэглээ болон жорын бичилт, эмийн эмчилгээний алдаа, эмийн гаж нөлөөний судалгааг жил бүр явуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хийх мэдээлэл, сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалт, мэдээллийн төлөвлөгөөг сургалтын алба болон даргаар баталгаажуулна.
- 1.2. Эмнэл зүйн эм зүйч эмнэлэгт шинээр бүртгэгдсэн болон эмнэлзүйн удирдамжид шинээр нэвтэрч буй эмийн шинж чанар, технологи, фармакологи, фармакинетик, аюулгүй байдал, хэрэглэх арга, жор бичилтийн талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд цаг тухай бүрд мэдээлэл, сургалт явуулна.
- 1.3. Жороор олгох эм, мансууруулах, сэтгэцэд нөлөөт болон өндөр эрсдэлт, адил дуудагддаг болон адил харагддаг эмийн жор бичилт, хэрэглээ, хадгалалт, тайлагнах, устгах болон аюулгүй ажиллагааны талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт, мэдээлэл хийнэ.
- 1.4. Эмийн нөөцийн тасгийн эм зүйч эм хадгалах, хянах, буцаах, устгах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, сургалтыг сувилагч, холбогдох эмнэлгийн мэргэжилтнүүдэд явуулна.
- 1.5. Эмийн талаарх хийсэн мэдээлэл, сургалтын бүртгэл хөтөлж, ЭЭЗХ болон ЭЭХХЗГ-т тайлагнана (Хүснэгт 1).
- 1.6. Эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагаас тус эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд хийх эмийн мэдээлэл, сургалтын материалыг Эм зүйн албаар хянуулж, зөвшөөрөл олгосон тохиолдолд Эмнэлгийн сургалтын албанд танилцуулан зохион байгуулна.

Хоёр. Үйлчлүүлэгчдэд эмийн мэдээлэл хийх, сургалт явуулах

- 2.1. Эм зүйн алба үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эмийн зохистой хэрэглээ, эмийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн сургалт, мэдээлэл, сурталчилгааг Эмнэлгийн сургалтын албаны хянаж баталгаажуулсан материал ашиглан тогтмол явуулна.
- 2.2. Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн, бодит эх сурвалжид үндэслэсэн, үнэн зөв мэдээлэл бүхий сургалт, мэдээллийг Үйлчлүүлэгч дэмжих албатай хамтарч зохин байгуулна.
- 2.3. Үйлчлүүлэгчдэд зориулсан сургалт, мэдээллийн эх материалд зарцуулагдах зардлыг Эм зүйн албаны төсөвт тусгаж, санхүүжилтийг зохицуулна.

Гурав. Эмийн мэдээлэлд хориглох зүйл

- 3.1. Эмийг импортлох, худалдах зорилгоор сурталчлах;
- 3.2. Хүүхдэд хандсан эмийн сурталчилгаа явуулах;
- 3.3. Эмчийн зөвлөгөө, эмчилгээ, мэс ажилбарыг үгүйсгэх ойлголт төрүүлэх мэдээлэл өгөх;
- 3.4. Эмийг ховор, чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй, үр дүн нь бусад эмээс илүү, аюулгүй, гаж нөлөөгүй, шинэ эм, патентлагдсан гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх;
- 3.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтад урамшуулал олгох буюу үнийн хямдрал үзүүлэх тухай мэдээлэл өгөх;
- 3.6. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг мэдээлэл өгөх;
- 3.7. Тухайн эмийн гаж үйлчлэл, хориглох заалтыг нуун далдлах зорилгоор мэдээлэл өгөх;
- 3.8. Эмийг зөвхөн худалдааны нэршлээр мэдээлэл өгөх;
- 3.9. Эмийн үйлчилгээний талаар магтсан, хэрэглэхийг уриалсан мэдээлэл өгөх, сурталчилгаа явуулахыг хориглоно.

Хүснэгт 1

Эмийн мэдээлэл, сурталчилгаа явуулсан тухай бүртгэл

[illegible]

Эрүүл мэндийн сайдын
оны.....сарын.....-ны өдрийн
....дугаар тушаалын 11 дүгээр хавсралт

Эм худалдан авах үйл ажиллагаа

Улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан, аюулгүй, эдийн засгийн хувьд боломжийн үнэтэй эмээр тасралтгүй хангах, хяналтын үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Эмийн захиалга

- 1.1 Эм зүйн алба жил бүр эмнэлгийн эмийн хэрэглээг өвчлөлийн үзүүлэлтээр болон зарцуулалтаар тооцон, эмийн хэрэглээний судалгааг явуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 1.2 Эм зүйн албаны нөөцийн тасгийн эм зүйч эмийн тасалдал үүсэхээс сэргийлж, эмийн тасалдлын бүртгэл хөтөлж, тасалдлын шалтгаан, хүчин зүйлд үндэслэн, эмнэлгийн эмийн захиалгыг хийхэд анхаарч ажиллана.
- 1.3 Эм зүйн албаны дарга, нөөцийн тасгийн эм зүйч эмийн хэрэглээний судалгаанд үндэслэн, эмийн захиалгыг төлөвлөнө.
- 1.4 Эм зүйн албаны дарга худалдан авах эмийн жагсаалтын төслийг Эмийн эмчилгээг зохицуулах хороогоор хэлэлцүүлж, батлуулна.

Хоёр. Эмийг худалдан авах үйл ажиллагаа


- 2.1 Худалдан авах ажиллагааг мэргэжлийн түвшинд ил тод, хууль тогтоомжид нийцсэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйтэй, үнэн зөв найдвартай мэдээллийн систем ашиглан цаг хугацаанд нь үр ашигтай явуулна.
- 2.2 Эмийн худалдан авалтыг худалдан авалтын холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулна.
- 2.3 Үнэлгээний хороо нь Эмийн эмчилгээний хорооны баталсан худалдан авах эмийн жагсаалтад үндэслэн, тендерээр худалдан авах эмийн багц, тэдгээрийн техникийн үзүүлэлтүүдийг боловсруулж, санал боловсруулна.
- 2.4 Батлагдсан тендерээр худалдан авах эмийн багцын саналыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д нээлттэй байршуулна.
- 2.5 Үнэлгээний хороо эм худалдан авах ханган нийлүүлэгчийг сонгох үйл ажиллагааг ил тод, мэргэжлийн ёс зүйтэй, хууль журмын дагуу гүйцэтгэх ба улсын бүртгэлгүй, стандартын бус, хуурамч эмийн бүтээгдэхүүн худалдан авахаас сэргийлэх үүргийг хүлээнэ.
- 2.6 Үнэлгээний хороо нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсан Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай гэрээний төсөлд санал оруулах, хянаж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.
- 2.7 Эмийн хүчинтэй хугацаа нь богино эсвэл эмийг их хэмжээгээр авах шаардлагатай бол үечилсэн худалдан авалтаар зохион байгуулна.
- 2.8 Эм зүйн албаны дарга тендерт шалгарсан Эм ханган нийлүүлэгчдээс эмийг худалдан авах эмийн хэрэгцээ, хүчинтэй болон хадгалалтын горимын

онцлогоос хамаарч график, төлөвлөгөөг гарган, хүлээн авах үйл ажиллагаанд хяналт тавина.

Гурав. Худалдан авсан эмийг хүлээж авах, шалгах

- 3.1. Эмийн төв агуулахын эм зүйч эсвэл эм найруулагч нар давхар хяналтын зарчмаар, “Эм хүлээн авах, шалгах хяналтын хуудас”-аар (Хүснэгт 2) захиалгаар ирсэн эм, бэлдмэлийг шалгаж, хүлээн авна.
- 3.2. Эм, бэлдмэлийг Эм ханган нийлүүлэх байгууллагаас татан авахдаа дагалдах бичиг баримттай тулгаж түгээлтийн зохистой дадлын шаардлагад нийцсэн тохиолдолд нэр төрлийн бүртгэлд орлого авч баримтжуулан хүлээж авна.
- 3.3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг хүлээж авахад “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтын журам”-ыг мөрдөж ажиллана.
- 3.4. Жор эм зүйч худалдан авсан эм, бэлдмэлийг хүлээн авах, шалгах үйл ажиллагааг мэргэжлийн ёс зүйтэй, хууль журмын дагуу гүйцэтгэх ба улсын бүртгэлгүй, стандартын бус, хуурамч эмийн бүтээгдэхүүн эмнэлэгт авахаас сэргийлэх үүргийг хүлээнэ.
- 3.5. Эмийн худалдан авалтын баримтыг эмийн татан авалт хийсэн өдрөөс хойш 3 жил хүртэл хугацаагаар Эм зүйн албан дээр хадгална.
- 3.6. Жор баригч эм зүйчид дараах тохиолдолд эм хүлээн авахаас татгалзана:
 - 3.6.1. Захиалсан эм биш бол;
 - 3.6.2. Эмийн чанарын байдалд эргэлзээ төрөхөөр бол;
 - 3.6.3. Эмийн хүчинтэй хугацаа 6 сарын дотор дуусах бол яаралтай хэрэгцээ байхгүй тохиолдолд;
 - 3.6.4. Хүйтэнд хадгалах бүтээгдэхүүнүүдийг тээвэрлэх явцад зохих температурт нь хадгалаагүй бол хүлээн авахаас татгалзана.

Хүснэгт 1.



Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах заавар

Амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тасагт эмчлүүлэгчдэд өндөр эрсдэлт эмийн жор бичих, эмчилгээнд хэрэглэх, эмчилгээний хяналт хийх болон эмээс шалтгаалах эрсдэлээс сэргийлэх, авах арга хэмжээг зохицуулж, эмийн аюулгүй байдлыг сайжруулах зорилготой.

Нэг. Өндөр эрсдэлт эмийн захиалга бэлтгэх, хадгалах

- 1.1. Эмнэлгийн өндөр эрсдэлт эмийн жагсаалтыг Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороо баталж, эмнэлгийн эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах үед хамтад нь шинэчилнэ.
- 1.2. Өндөр эрсдэлт эмийн бүлэгт дараах бүлгийн эмийг хамруулна:
 - 1.2.1. Судас идэвхт эм (Vasoactive)
 - 1.2.1. Антикоагулянт
 - 1.2.2. Өндөр концентрацтай электролитийн уусмал
 - 1.2.3. Инсулин
 - 1.2.4. Мансууруулах, сэтгэц нөлөөт эм
 - 1.2.5. Мэдрэл -булчинг хориглогч (Neuromuscular blocking agent)
 - 1.2.6. Хэсэг газрын мэдээ алдуулах эм
 - 1.2.7. Хими эмчилгээний эмүүд
 - 1.2.8. Адил дуудагддаг, адил харагддаг эм
- 1.3. Өндөр эрсдэлт, адил дуудагддаг, адил харагддаг эмүүдэд утсаар болон аман захиалга хийхгүй.
- 1.4. Өндөр эрсдэлт эмийн жагсаалтад хадгалалтын тусгай горим шаардлагатай болон эмийн нөөцтэй тасаг нэгж, тэргэнцрийн байршлыг тэмдэглэсэн байна (Хүснэгт 1).
- 1.5. Эм зүйн албанд өндөрт эрсдэлт эмийн жор бэлтгэх үйл явцад дараах зарчмыг мөрдөж ажиллана:
 - 1.5.1. Өндөрт эрсдэлт эмийн захиалгын дагуу эм олгох үйл ажиллагааг “Хэвтэн эмчлүүлэх тасагт эм олгох үйл ажиллагааны заавар”-ын дагуу, давхар хяналтын зарчим мөрдөж ажиллана.
 - 1.5.2. Өндөрт эрсдэлт эмийн жорыг бэлтгэхэд нэгж тунгийн зарчмаар бэлтгэж, нэг дор олон хоногийн тунг олгохгүй.
 - 1.5.3. Өндөр эрсдэлт эмийг тусгай анхааруулга, өнгө бүхий шошго нааж түгээнэ (Хүснэгт 2)
 - 1.5.4. “Адил харагдах эм”, “Адил дуудагдах эм”-ийн шошгонд адил дуудагддаг, харагддаг үеийг ТОМ үсгээр бичнэ. (Хүснэгт 3)
- 1.6. Тасаг, нэгжид байрлах өндөр эрсдэлт эмийг хадгалах шүүгээ, тавиурт “Өндөр эрсдэлт эм”, “Адил харагдах эм”, “Адил дуудагдах эм” гэсэн ялгах тэмдэг байршуулсан байна (Хүснэгт 2).

- 1.7. Өндөр эрсдэлт эмийг хадгалах шүүгээнд хадгалж буй эмийн жагсаалт, тоо хэмжээ, хяналтын хуудсыг байршуулж, шүүгээний орлого, зарлагыг ээлжийн ахлах сувилагч хянана.

Хоёр. Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах

- 2.1. Өндөр эрсдэлт эмийг эмчилгээнд хэрэглэх үед сувилагч хяналт тавьж ажиллах ба шаардлагатай тохиолдолд эмчийн хяналтад хийнэ (Хүснэгт 4).
- 2.2. Судсаар хэрэглэх эмийг зориулалтын тариур болон системээр хийж, шахуургын тохиргоо, тарилгын хурд зэргийг хянан, аюулгүй ажиллагааг мөрдөнө.
- 2.3. Судсаар хэрэглэх өндөрт эрсдэлт эмийг шингэлсэн дуслын шингэний уут, савлагаа дээр эмийг хэрэглэж эхэлсэн огноо, цагийг тэмдэглэж, эмийн ампулыг нааж бэхэлнэ.
- 2.4. Эм хэрэглэсэн арга, огноо, цаг, эмчилгээний хяналтын (шинжилгээ, амин үзүүлэлт г.м) үзүүлэлтүүд болон эмийг хэрэглэх үед илэрсэн сөрөг нөлөө, авсан арга хэмжээний тухай болон тэмдэглэлийг эмчилгээний хуудсанд тэмдэглэнэ.
- 2.5. Тасагт өндөр эрсдэлт эмийг үйлчлүүлэгчийн дэргэд түр орхих болон эмийн саванд байлгахыг хориглоно.
- 2.6. Эмнэлзүйн эм зүйч хариуцсан тасгийн үйлчлүүлэгчдийн эмчилгээнд хэрэглэсэн өндөр эрсдэлт эмийн жорын болон хэрэглээний хяналтыг өдөр бүр хянана.
- 2.7. Өндөр эрсдэлт эмийг хэрэглэх үед эмийн гаж нөлөө илэрсэн үед эмчлэгч болон жижүүрийн эмчид яаралтай мэдэгдэж, эмчилгээний арга хэмжээг авсны дараа “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”-ын дагуу арга хэмжээг авна.
- 2.8. Өндөр эрсдэлт эмийн хэрэглээтэй холбоотой эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдол илэрсэн үед “Эмийн эмчилгээний алдааг бүртгэн мэдээлэх, зохицуулах журам”, Тохиолдол мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”-ын дагуу арга хэмжээ авна.

Гурав. Эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаа

- 3.1. Эмнэлзүйн эм зүйч хариуцсан тасаг нэгжийн өндөр эрсдэлт эмийн хэрэглээ, орлого, зарлага болон хадгалалтыг тогтмол хянана.
- 3.2. Эмнэлзүйн эм зүйч өндөр эрсдэлт эмийн жор бичилт, эмийн хэрэглээнд үнэлгээ, судалгаа хийж тасаг хариуцсан эмнэлзүйн эм зүйч эмийн эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдлыг эрт илрүүлэхэд хяналт тавьж, Эм зүйн албаны дарга “Эмийн эмчилгээний хороо”-нд жил бүр тайлагнаж, эмнэлгийн нийт мэргэжилтнүүдэд мэдээлнэ.
- 3.3. Эм зүйн алба эмнэлэгт хэрэглэх өндөр эрсдэлт эмийн талаар эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлэл, сургалт зохион байгуулах, эрсдэлээс сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулна (Хүснэгт 5) .
- 3.4. Эм зүйн алба амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэгч, асран хамгаалагчдад өндөр эрсдэлт эмийн зохистой хэрэглээ, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний талаар эрүүл мэндийн боловсрол олгоно.

Хүснэгт 1.

Өндөр эрсдэлт эмийн жагсаалт

Хүснэгт 1. Өндөр эрсдэлт эмийн жагсаалт			
Өндөр эрсдэлт эмийн бүлэг	Өндөр эрсдэлт эмийн нэр	Эмийн тун хэмжээ	Эмийн хэлбэр
Адренорецептор сэргээх эмүүд			
Адренорецептор саатуулах эмүүд /Бета-адреноблокатор/			
Инотропэм			
Сэтгэц засах тайвшруулах эм			
Антикоагулянт эмүүд			

Цусны сахар бууруулах эм			
Элетролитийн тэнцвэрт нөлөөлөх эм /Өндөр концентрацитай тарилгын уусмал/			
Мансууруулах сэтгэц нөлөөт эмүүд			
Мэдрэл булчинд хориг үүсгэдэг эмүүд			
Мэдээгүйжүүлэх эмүүд			
Хэм алдалтын эсрэг эм			

Хүснэгт 2.



Хүснэгт 3.

Адил дуудагддаг эмийн жагсаалт

1	<u>ЭПИ</u> нефрин 1мг/мл	<u>ЭФЕ</u> дрин 5%-1мл
2	<u>КЕТО</u> профен 100 мг	<u>КЕТО</u> тифен 1мг
3	ХЛО <u>Р</u> фенамин 4мг	ХЛО <u>Р</u> амфеникол 500мг
4	<u>ИМО</u> пек 2мг	<u>ИМО</u> пер
5	<u>АПРОТОН</u> нин 10,000 ед/мл 10мл	<u>АТРОП</u> ин 0.1%-1мл
6	<u>ЛАН</u> пурин 100мг	<u>ЛАН</u> сорбид 5мг
7	<u>АМИО</u> дарон 200мг	<u>АМЛО</u> дипин 10мг
8	<u>НИФ</u> едипин 20мг	<u>НИК</u> ардипин 25мг/10мл
11	Ана <u>ПРИЛИН</u> 40мг /пропорнолол/	Энала <u>ПРИЛ</u> 10мг
12	ОК <u>Т</u> реотид 0.05 мг/мл	ОНДансетрон 8мг/4мл

13	ОктреотИД 0.05 мг/мл	АктраПИД 40ед/1мл-10 мл
14	<u>АЦЕТА</u> минофен 500мг	<u>АЦЕТА</u> золамид 250 мг
15	<u>АЦЕТИЛ</u> салицилийн хүчил 75мг, 100 мг	<u>АЦЕТИЛ</u> цистейн 100мг, 200мг, 600мг
16	Дро <u>ПЕРИ</u> дол 2.5мг/мл-5мл	Дом <u>ПЕРИ</u> дон 10мг
17	<u>МЕТ</u> формин 500мг	<u>МЕТ</u> опролол 50мг

Хүснэгт 4.

Өндөр эрсдэлт эмийн давхар хяналтын хуудас

№	Давхар хяналтын үед шалгах асуулт	Судилагч 1	Сувилагч 2
1	Эмийн захиалга хийсэн үйлчлүүлэгчийн түүх, нэр тохирч байна уу?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй
2	Эмийн захилга хийсэн огноо хамгийн сүүлийнх мөн үү?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй
3	Жоронд захиалсан эмийн нэр мөн үү?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй
4	Эмийн тун, тоо, хэлбэр мөн үү?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй
5	Эмийг хэрэглэх давтамж, хэрэглэх арга зөв үү?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй
6	Тарилгын шахуургад оруулсан эмийн концентраци болон тарилгын хурд (жишээ нь: mcg/kg/min)-ны тохиргоо зөв үү?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй
7	Эмийн тун, тарилгын хурд өөрчлөгдсөн үү?	☐ Тийм, ☐ Үгүй	☐ Тийм, ☐ Үгүй

Хүснэгт 5.

Өндөр эрсдэлт эмийн гарч болзошгүй эрсдэл, авах арга хэмжээ

Эмийн бүлэг	Эмийн нэрс	Гарч болзошгүй эрсдэл	Алдаа гарахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
Адренорецепторыг сэргээх эмүүд	Эпинефрин 1мг/1мл	- Хаягжилт дутмаг - Тун, концентрацийн ялгааг андуурах	- Захиалгын хэлбэрийг стандартжуулах - Бүх савлагааг хаягжуулах - Хэрэглэхээс өмнө эмийн тун, пампын тохируулгыг дахин шалгах - Үйлчлүүлэгчийн зүрхний үйл ажиллагааг хянах
Инотроп эм	Допамин 200 мг/5мл ба добутамин 5мг/5 мл	- Адил дуудагдаж, сонсогддог учраас андуурагдан хэрэглэгдэх магадлалтай. - Тарилгын хурдыг тооцохдоо алддаг. (мкг/кг/минут) - Судасны гадуур тарих эрсдэлтэй	- DOBUamine DOPamine гэж ялгааг тодотгон хаягжуулах - Захиалах тун ба тарих хурдыг тооцох тогтсон стандарттай байх
	Дигоксин 0.025%-1 мл	- Бусад бүлгийн эмүүдтэй харилцан нөлөөл ихтэй, - Тун хоорондын зайг буруу тооцох	- Хэрэглээг хянах, үнэлэх протокол хөтлөх - Тун тооцож, стандартчил. - Ялангуяа настнуудад анхааралтай хэрэглэх.
Сэтгэц засах тайвшруулах эм	Диазепам 0.5%-2 мл	- Тун хоорондын зайг зөв тооцох - Тарилгын савлагааны тунг % ба мг/мл хэмжээгээр ялгаатай илэрхийлснээс гарах алдаа	- Эмийн зохистой хэрэглээг хянах - Зөвхөн нэг тунгийн хэмжигдэхүүнээр илэрхийлэх
Антикоагулянт эмүүд	Гепарин 5000ЕД/1мл- 5 мл	- Тунгийн алдаа, концентрацийн алдаа 1 флакон ба 1мл-т агуулагдах нэгж тунг андуурах	- Адил харагдах, дуудагдах эмүүдээс холдуулах - Анхааруулах тэмдэглэгээ тавих - Давхар хяналтыг хийх - Гепарин хэрэглээний үйлдлийг стандартчилах - Нэгж тунгаар хэрэглэгдэх эмүүдээс холдуулах - Тунг биеийн жинд үндэслэн тооцох - Пампын тохируулгыг хянах - Гепарин хольж шингэлсэн дусалд тэмдэг тавих.
Цусны сахар бууруулах эм	Инсулин	- Их тунгаар тарих - Пампын тохиргооноос шалтгаалсан алдаа - Адилхан дуудагдах эмүүдтэй андуурагдах /humulin/ - Инсулин хийх заалтгүй буруу үйлчлүүлэгчид тарих	- U гэсэн тэмдэглэгээний оронд Unit гэж бүтэн бичиж хэвших - Нэгж тунг зөв тооцох - Гепарин ба инсулиныг тусд нь байрлуулах - Пампын тохиргоог давхар шалгах - Тарих үйл явцыг стандарчил / тариур/ - Урт ба богино хугацааны үйлдэлтэй инсулинуудыг ялгах

Элетролитийн тэнцвэрт нөлөөлөх эм /өндөр концентрацитай тарилгын уусмал/	Калийн хлорид 7.5%-100	• Өндөр тунгаар хэрэглэх /зүрх зогсох эрсдэлтэй/ • Тарилгын хурд буруу тооцох • Бусад тарилгын уусмалтай андуурагдах	• Андуурагдахааргүй газарт зөв байрлуулах • Калийн хлорид хэрэглэх заалт • Дуслын хамгийн дээд хурд • Тарьж болох дээд концентраци • Зүрхний үйл ажиллагааг хянах удирдамж • Пампын тохиргоо • Калийн бэлдмэлийг тарьсаны дараа санамсаргүйгээр дахин таригдах эрсдэлээс сэргийлэх • Судсанд тарихаас уух хэлбэрээр шилжүүлэн хэрэглэх боломжтой эсэхийг үнэлэх
	Натрийн хлорид 3 %-250мл		
	Магнийн сульфат 25%-10	• MSO_4 & MgSO_4 (морфин сульфат ба магнийн сульфат) товчлолыг андууран хэрэглэх • mg, mEq, mL зэрэг олон хэмжигдэхүүнийг андуурах • Пампын тохиргооны алдаа	• Протокол хөтлөх • Тунг тооцох талаар сургалт явуулах • Химийн нэршлээр бүү товчил • Тунг тооцох, пампын тохиргоог давхар шалгах тогтолцоо • Эмчилгээний тасагт их хэмжээгээр нөөцлөхгүй байх /гарах эрсдлээс сэргийлж/
	Кальцийн глюконат 10%-10 мл Кальцийн хлорид 10%-10 мл	• Кальцийн хэмжээг зөв тооцох • Судсанд тарих үед алдаа гаргаж булчинг гэмтээх • Дигоксин хэрэглэж байгаа үйлчлүүлэгчид кальцийг бэлдмэлийг тарих хурднаас хамааран брадиаритм үүсгэнэ. • Кальцийн сувагт хориг үүсгэх эмүүд болон даралт бууруулах эмүүдтэй антагонист үйлдэлтэй. • Гипокальциемитэй үйлчлүүлэгчид кальцийн дутагдлын түвшинг хянах • Кальци хлоридын шалтгаантай эдийн үхжил үүсэх	• Хэрэглээг хянах, үнэлэх протокол хөтлөх • Тунг тооцож, стандартчил. • Кальцийг зөвхөн миллиграммаар захиалах
Мансууруулах сэтгэц нөлөөт эмүүд	Морфин 1%-1мл Фентанил 0.005%-2мл Трамадол 2.5%-2мл	• Сувилагчийн тарилгын хэсэгт ил байснаас андуурагдах • Эмийг таних, бэлтгэх, тарих явцад 1 сувилагч гүйцэтгэснээс хамаарсан алдаа • Өвдөлт намдаах хүчийг буруу тооцох • Тунг, давтамж, хурдыг үйлчлүүлэгчид	• Гарч болох эрсдлийн талаар сургалт тогтмол хийх • Судсанд тарих эмийн концентрацийг стандартчилах • Нэг флаконд агуулагдаж буй эмийн концентрацийг тооцох • Зөвхөн олон улсын нэршлээр нэрлэх • Тунг тооцох, пампын тохиргоог давхар шалгах тогтолцоо

		тохируулаагүйгээс гарч буй алдаа • Харшлын урвал илрэх • Пампаас шалтгаалах алдаа	• Үйлчлүүлэгчийг харшилтай эсэхийг асууж хэвших
Мэдрэл булчинд хориг үүсгэдэг эмүүд	Суксаметон ы хлорид 100мг/2мл Векуроны бромид 10мг	• Хагалгааны өрөөнөөс бусад хэсэгт ил байрлуулсан тохиолдолд андуурагдан тарих эрсдэл • Адил харагдах вакцин бусад тарилгатай андуурагдах эрсдэл	• Бусад эмүүдээс ялгагдах тэмдэглэгээтэй байх • Хадгалах байрлалыг тодорхойлох • Шаардлагагүй тасгуудад байрлуулахгүй байх

Эрүүл мэндийн сайдын
оны.....сарын.....-ны өдрийн
.....дугаар тушаалын 13 дугаар хавсралт

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтын үйл ажиллагаа

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг хүлээн авч бүртгэх, хадгалах, түгээх, устгах болон эмийн хэрэглээг хянах үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Үйл ажиллагааны зарчим

- 1.1. Эмнэлэгт хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тухай холбогдох журам, дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.
- 1.2. Эм зүйн албаны дарга болон эм зүйч мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн захиалга, татан авалт, бүртгэл, зарцуулалт, түгээлт болон хэрэглээг хариуцна.
- 1.3. Тасгийн эрхлэгч, ахлах сувилагч тухайн тасаг нэгжид хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалга, хадгалалт, хэрэглээний хяналтыг хариуцна.
- 1.4. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Эмийн эмчилгээг зохицуулах хорооны дарга/ тасаг нэгжид хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалгыг баталгаажуулах, хянах ажлыг хариуцна.

Хоёр. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн бүртгэл хөтлөлт, түгээлт, хадгалалт

- 2.1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нөөцийн шүүгээ /сейфны/ байрших тасаг нэгж, эмийн жагсаалтыг Эмийн эмчилгээг зохицуулах хороогоор хэлэлцэн, Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалын дагуу эмнэлзүй, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга баталгаажуулна.
- 2.2. Эмнэлэгт хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг гэрээт ханган нийлүүлэгч байгууллагын зөвхөн хариуцсан мэргэжилтнээс эм зүйн албаны нөөцийн эм зүйч болон жор баригч, эм зүйч нар давхар хяналтын зарчмаар хүлээн авна.
- 2.3. Нөөцийн тасгийн эм зүйч мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг савлагааны хамгийн бага нэгжээр нь бүртгэн авч, бүртгэлийн дэвтэрт орлогыг тэмдэглэнэ.
 - 2.3.1. Эмийн орлогыг улаан өнгийн бэхээр /балаар/ бичнэ.
 - 2.3.2. Зарлага буюу хэрэглэсэн эмийг хар өнгийн бэхээр /балаар/ тэмдэглэнэ.
- 2.4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг ханган нийлүүлэгчээс хүлээн авахад дараах хяналтын зарчмыг мөрдөнө:
 - 2.4.1. Эмийн Монгол Улсад бүртгэсэн бүртгэлийн дугаар, бүртгэлийн хүчинтэй хугацаа
 - 2.4.2. Нийлүүлэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ

- 2.4.3. Эмийн цувралын дугаар, түүний худалдан авалтын баримт болон бусад холбогдох баримт бичгийн тохирол
- 2.4.4. Эмийн савлагаа, тоо хэмжээ, хүчинтэй хугацаа, эмийн гаднах чанарын үзүүлэлтүүдийн тохирол
- 2.5. Эм хүлээн авах үед гэмтсэн, дутсан тохиолдолд тухайн эмийг буцааж, эм хүлээлцэх баримт дээр тэмдэглэн, хоёр талын хариуцсан мэргэжилтнүүд гарын үсгээр баталгаажуулан, нэг хувийг Эм зүйн албанд баримтжуулна.
- 2.6. Эмнэлгийн тасаг, нэгжийн ахлах сувилагч тухайн тасагт хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалгын түүврийг ЭМС-ийн холбогдох тушаалаар батлагдсан захиалгын хуудсаар хийж, тасгийн эрхлэгч баталгаажуулна.
- 2.7. Тасаг, нэгжийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалгыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан, тасгийн ахлах сувилагч Эм зүйн албанд хүргэнэ.
- 2.8. Тасгийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээнд үндэслэн, 7 хоногийн нөөцийн захиалга хийнэ.
- 2.9. Эм зүйн албанд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг цоожтой төмөр шүүгээ /сейф/-нд хадгалж, түлхүүрийг зөвхөн эм зүйн албаны дарга, нөөцийн тасгийн эм зүйч хадгална.
- 2.10. Тасаг, нэгжийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг цоожтой төмөр шүүгээ /сейф/-нд хадгалж, түлхүүрийг тасгийн ахлах сувилагч, ээлжийн ахлах сувилагч хадгална.
- 2.11. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нөөцийн шүүгээгүй тасагт “Яаралтай тусламжийн эмийн шүүгээ”-ний цоожтой хэсэгт эмийг батлагдсан эмийн нэр төрөл, тоогоор хадгална.
- 2.12. “Яаралтай тусламжийн эмийн шүүгээ”-нээс хэрэглэсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг цаасан болон цахим бүртгэлд сувилагч тухай бүр тэмдэглэнэ.
- 2.13. “Яаралтай тусламжийн эмийн шүүгээ”-ний хэрэглэсэн эмийн бүртгэлийг тасаг хариуцсан эмнэлзүйн эм зүйч хянаж, тухайн өдөрт нөхөж дүүргэнэ.
- 2.14. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн шошголох, хадгалах, хяналтын үйл ажиллагааг “Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах” хавсралтаар зохицуулна.
- 2.15. Мансууруулах эмийг үйлдвэрийн савласан хэмжээнээс бага тун, хэмжээгээр үйлчлүүлэгчид хэрэглэх тохиолдолд илүү гарсан эмийн үлдэгдлийг эмзүйн албаны даргын хяналтын дор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хариуцдаг эмзүйчийг байлцуулан устгаж баримтжуулна.
- 2.16. Эмийн сан нь мансууруулах эмийн хоосон тун шил, шахмал эмийн савыг буцаан авсан тухай тусгай бүртгэл хөтлөн, жилд нэг удаа комисс томилон, хөндлөнгийн гэрч байлцуулан устгана. /Хүснэгт 5/

Гурав. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээг хянах

- 3.1. Эм зүйн алба стандартын дагуу хэвлэгдсэн Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг журмын дагуу захиалан авна.

- 3.2. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичих зөвшөөрөгдсөн поликлиникийн тасгийн эмч мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн тусгай жорын маягтаар, эмийн жорыг журмын дагуу бичнэ.
- 3.3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг жор баригч эм зүйч тасгийн ахлах сувилагчид орлого, зарлагын дэвтэрт тэмдэглэн хүлээлгэн өгч, хяналт тавина.
- 3.4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтыг поликлиникийн ахлах сувилагч хөтлөн, тасгийн жор баригч эм зүйч хянан, бүртгэл хөтлөн, тайланг гаргана. /Хүснэгт 2,3/.
- 3.5. Хэвтэн эмчлүүлэх тасагт эмч Эмнэлгийн мэдээллийн систем болон өвчний түүхэнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичсэн тохиолдолд захиалгыг хэвлэн, эмийн эмчилгээг эмчлүүлэгчид хийсэн сувилагч болон захиалга хийсэн эмч гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.
- 3.6. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нөөцийн шүүгээтэй тасагт эмийг нөөцийн шүүгээнээс хэрэглэж, сувилагч эмийн хэрэглээний бүртгэлийн дэвтэрт /Хүснэгт 1/ журмын дагуу тэмдэглэнэ.
- 3.7. Тасгийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээний бүртгэлд тасгийн ахлах сувилагч хяналт тавьж, баталгаажуулна.
- 3.8. Тасагт хэрэглэсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалгын хуудас, хэрэглэсэн эмийн хоосон туншил, шахмалын савыг дараа өдрийн 10-11 цагийн хооронд тасаг хариуцсан эм зүйч Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн бүртгэлийн дэвтэр, захиалгын хуудас болон эмийн хоосон савны нэр, серийн дугаар, эмийн тун, үлдэгдлийг тулган хүлээн авч, баталгаажуулна (Хүснэгт 4).
- 3.9. Хэвтэн эмчлүүлэх тасагт мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилт болон эмийн хэрэглээнд тасаг хариуцсан эмнэлзүйн эм зүйч “Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах” хавсралтын дагуу хяналт тавьж ажиллана
- 3.10. Нөөцийн тасгийн эм зүйч Эм зүйн албаны мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн шүүгээний орлого, зарлага, хэрэглээний бүртгэлд 7 хоног бүр хяналт хийж, сар бүр тайлан гаргана.
- 3.11. Тасгийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг дараах үзүүлэлтээр хянана:
 - 3.11.1. Эмийн хадгалалтын горим
 - 3.11.2. Эмийн серийн дугаар
 - 3.11.3. Эмийн дуусах хугацаа
 - 3.11.4. Эмийн тоо хэмжээ зарцуулалт ба бүртгэлийн тохирол

Дөрөв. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтын тайлан

- 4.1. Эм зүйн албаны эм зүйч Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилт, хэрэглээ, хадгалалт, хяналтын тайланг сар бүр гаргана.
- 4.2. Эм зүйн албаны дарга эмнэлгийн Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилт, хэрэглээ, хадгалалт, хяналтын тайланг улирал бүр эмийн эмчилгээг зохицуулах хороонд тайлагнаж, Эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга баталгаажуулна.
- 4.3. Эрүүл мэндийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалт, устгал, жор бичилт, жорын маягтын

зарцуулалтад эрүүл мэндийн байгууллагын чанарын алба хяналт тавьж ажиллана.

- 4.4. Эм хангамжийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, түгээлт, зарцуулалт, устгалд чанарын менежер хяналт тавьж ажиллана.
- 4.5. Эм зүйн албаны дарга эмнэлгийн “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилт, хэрэглээ, хадгалалт, хяналт”-ын тайлан болон зөвлөмж, анхааруулгыг улиралд нэг удаа эмнэлгийн нийт мэргэжилтнүүдэд эргэн мэдээлэл хийнэ.
- 4.6. Эмзүйн албаны дарга мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын тайлан” жорын маягтаа зарцуулж дуусах тухай бүрт харьяа ЭМГ-ын хариуцсан мэргэжилтэнд тайлагнана.
- 4.7. Эмзүйн албаны дарга мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан”-г холбогдох журмын дагуу хугацаанд нь тайлагнана.

Хүснэгт 1.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл

Эмнэлэг, тасгийн нэр _____

Эмийн нэр, тун хэмжээ _____ Хэмжих нэгж _____

[illegible]

Хүснэгт 2.

Мансууруулах эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл

№	Жорын индекс	Үйлчлүүлэгчийн нэр, регистрийн дугаар	Онош	Жоронд бичсэн эмийн нэр, тун, хэлбэр	Жор бичсэн эмчийн нэр, тасаг
1					
2					
3					

Сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл

№	Жорын индекс	Үйлчлүүлэгчийн нэр, регистрийн дугаар	Онош	Жоронд бичсэн эмийн нэр, тун, хэлбэр	Жор бичсэн эмчийн нэр, тасаг
1					
2					
3					

Хүснэгт 3.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын тайлан

Эмнэлгийн нэр _____ оны сарын өдөр

Жорын маягт хүлээн авсан огноо	Жорын маягтын нэр, төрөл	Хүлээн авсан жорын маягтын		Зарцуулсан жорын маягтын		Үлдэгдэл	
		индекс	тоо	индекс	тоо	индекс	тоо

Хүснэгт 4.

Тасагт хэрэглэсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн туншил, сав буцаан хүлээж авсан бүртгэл

№	Огноо /цаг/	Буцаан авсан туншил, савны тоо	Буцаан авсан туншил, савны серийн дугаар	Ахлах сувилагчийн гарын үсэг	Эм зүйчийн гарын үсэг

1					
2					
3					

Хүснэгт 5.

Эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэц нөлөөт эм/түүхий эдийн устгалын бүртгэл

№	Эм, эмийн түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	Цувралын дугаар	Устгасан тоо хэмжээ	Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийн дугаар	Шийдвэр гаргасан эрхийн актын дугаар, огноо	Тайлбар

Эрүүл мэндийн сайдын
оны.....сарын.....-ны өдрийн
.....дугаар тушаалын 14 дүгээр хавсралт

Бичил биетний эсрэг эмийн хэрэглээг хянах, зохицуулах заавар

Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг бий болгох, бичил биетний эсрэг эмийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх, эмийн аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Бичил биетний эсрэг эмийн жор бичилт, хэрэглээг хянах

- 1.1. Эмнэлзүйн эм зүйч хариуцсан тасагт үйлчлүүлэгчдийн эмийн жоронд бичигдсэн бичил биетний эсрэг эмийн хэрэглээг хянах үйл ажиллагаанд “Үйлчлүүлэгчийн эмийн жорын хяналтын журам-ыг мөрдөж ажиллана.
- 1.2. Үйлчлүүлэгчийн жоронд бичигдсэн бичил биетний эсрэг эмийг эмчилгээнд хэрэглэх болон солих заалт нь үйлчлүүлэгчийн эмнэлзүйн байдал болон лабораторийн шинжилгээнд үндэслэгдсэн эсэхийг хянасны дараа жор бэлтгэнэ.
- 1.3. Урьдчилан сэргийлэх эмчилгээний болон эмперик сонголтоор төлөвлөсөн тохиолдолд эмчилгээний хугацааг 24 цагаас 3 хоног хүртэл хугацаанаас хэтрэхгүй байна.
- 1.4. Эмнэл зүйн эм зүйч цахим жорд бичигдсэн бичил биетний эсрэг эмийг “Эмнэлгийн бичил биетний эсрэг эмийн удирдамж”-ийн дагуу төлөвлөсөн эсэхэд хяналт тавина:
 - 1.4.1. Бичил биетний эсрэг эм хэрэглэх заалт,
 - 1.4.2. Бактериологийн болон мэдрэг чанарын шинжилгээ,
 - 1.4.3. Эмийн харшлын түүх
 - 1.4.4. Бичил биетний эсрэг эмийн сонголт, тун, тунгийн дэглэм, хэрэглэх арга,
 - 1.4.5. Бичил биетний эсрэг эм болон бусад хамт хэрэглэх эмийн харилцан нөлөөлөл үзүүлэх эрсдэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд эмийг солих, нэмэлт шинжилгээний саналыг эмчид танилцуулна.
- 1.5. Сувилагч бичил биетний эсрэг эмийн сорил тавьж, үр дүнг үйлчлүүлэгчийн цахим мэдээллийн санд тэмдэглэнэ.
- 1.6. Бичил биетний эсрэг эмийн сорил эерэг гарсан тохиолдолд эмчлэгч эмчид танилцуулж, эмчилгээг сольсон тохиолдолд мөн тэмдэглэл хөтөлнө.
- 1.7. Ээлжийн сувилагч бүр бичил биетний эсрэг эмчилгээ хийлгэж буй үйлчлүүлэгчийн биеийн температур, эмнэл зүйн шинж тэмдгийг тогтмол хянаж, цахим бүртгэлд бүртгэнэ.
- 1.8. Бичил биетний эсрэг эмийг хэрэглэснээс үүдсэн эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд эмчлэгч эмч болон жижүүрийн эмчид яаралтай мэдэгдэн, шаардлагатай эмчилгээний арга хэмжээ авч, үйлчлүүлэгчийн цахим

мэдээллийн санд бүртгэнэ.

- 1.9. Гаж нөлөө, эмийн харилцан нөлөөлөл үүссэн тохиолдлыг сувилагч “Гаж нөлөө бүртгэн мэдээлэх”, “Тохиолдол бүртгэн мэдээлэх журам”-ын дагуу мэдээлнэ.

**Хоёр. Бичил биетний эсрэг эмийн хэрэглээний тайлан мэдээлэх,
эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаа**

- 2.1. Эм зүйн албаны дарга Эмнэлгийн бичил биетний эсрэг эмийн хэрэглээний судалгаа хийж тайланг жил бүрийн 12 сарын сүүлийн долоо хоногт багтаан Эмийн эмчилгээг зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 2.2. Эм зүйн албаны дарга болон Эмнэл зүйн эм зүйч бичил биетний эсрэг эмийн хэрэглээний судалгаа, харилцан нөлөөлөл, түүнээс үүдсэн гаж нөлөөний тохиолдолд дүн шинжилгээ хийн, дахин үүсэх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг Бичил биетний эсрэг эмийн дэд хороотой хамтран зохион байгуулж ажиллана.
- 2.3. Антибиотик эмийн дэд хороо бичил биетний эсрэг эмийн хэрэглээний нотолгоонд суурилсан судалгааны дүнг жил бүр эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.4. Эмнэл зүйн эм зүйч нь эмнэлэгт үйлчлүүлэгч, иргэдэд зориулсан бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээ, гаж нөлөөнөөс сэргийлэх сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулна.

Эрүүл мэндийн сайдын
оны.....сарын.....-ны өдрийн
....дугаар тушаалын 15 дугаар хавсралт

Эмнэлэгт судалгааны эм хэрэглэх заавар

Эмнэлзүйн судалгааны болон эмнэлгийн эмчилгээ оношилгоонд шинээр нэвтрүүлж буй эмийг хэрэглэх ба эмчилгээний үр нөлөө болон аюулгүй байдлыг хянах үйл ажиллагааг зохицуулна.

Нэг. Судалгааны эм хэрэглэх зөвшөөрөл авах

- 1.1. Шинэ эмийн эмнэлзүйн судалгаа, эмчилгээ оношилгоонд шинээр нэвтрүүлж буй эмнэлзүйн судалгааны эмийг эмнэлэгт хэрэглэх зөвшөөрлийг эмнэлгийн Эмнэл зүйн хороо хэлэлцэн зөвшөөрөл олгоно.
- 1.2. Монгол Улсаас өөр улсад явагдаж буй эмийн бүртгэлийн өмнөх болон дараах эмнэлзүйн судалгааны оролцож буй судалгааны багийн судалгаа, түүнд хэрэглэх эмийг эмнэлэгт хэрэглэх тохиолдолд Монгол Улсын хууль, дүрэм журмын дагуу үүрэг хариуцлагыг хүлээх үүрэгтэй хүн, байгууллагатай хамтран ажиллах гэрээг зөвшөөрөл олгоно.
- 1.3. Эмнэл зүйн хороо эмнэлэгт судалгааны эм хэрэглэх асуудлыг хэлэлцэн, дараах тохиолдолд зөвшөөрөл олгоно:
 - 1.3.1. Био-Анагаахын Ёс зүйн хяналтын хорооноос эмнэлзүйн судалгаа явуулах зөвшөөрөл авсан байна.
 - 1.3.2. Эмийн эмнэл зүйн судалгааны судалгааны загвар, арга, аргачлалыг АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулсан.
 - 1.3.3. Эрсдэлийн менежмент, эмийн аюулгүй байдлыг хянах, бүртгэх, мэдээлэх төлөвлөгөө боловсруулсан.
 - 1.3.4. Эмнэлгийн Эрсдэлийн удирдлагын хороогоор эмнэл зүйн судалгааны арга, аргачлал болон хэрэглэх эмийн эрсдэлийн үнэлгээг хийлгэсэн дүгнэлт гаргуулсан.
 - 1.3.5. Эмнэлгийн Эм зүйн албанаас судалгааны эмэнд тавигдах шаардлага хангасан дүгнэлт гаргасан.
- 1.4. Эмнэл зүйн судалгаанд ашиглах эмийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:
 - 1.4.1. Эмнэл зүйн судалгаанд хэрэглэх эмийн эмнэлзүйн өмнөх фармакологийн, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг судлан тогтоож, гаж нөлөө багатай, эмчилгээний үр нөлөө сайн болох нь судлан тогтоогдсон, судалгааны үр дүнг мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн;
 - 1.4.2. Эмнэл зүйн судалгаанд хэрэглэх эмийг химийн болон чанарын судалгааг “Лабораторийн зохистой дадал”-ын горимын дагуу судлан тогтоосон;
 - 1.4.3. Эмнэл зүйн судалгаанд хэрэглэх эмийг “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” нэвтрүүлсэн эмийн үйлдвэрт бэлтгэсэн байна;

- 1.4.4. Судалгааны эмийн технологи, фармакокинетик шинж чанарын судалгааг хийсэн;
- 1.4.5. Судалгааны эмийг хэрэглэх тун, тунгийн дэгдэм, хэрэглэх арга, гарч болох гаж нөлөөний талаар зааврын төсөл боловсруулсан судалгааны шинэ бүтээгдэхүүнийг эмнэлзүйн судалгаанд ашиглана.

Хоёр. Судалгааны эмийн хэрэглээний бүртгэл, мэдээлэл

- 2.1. Судлаач судалгааны эм болон харьцуулах стандарт эмийн хэрэглээний талаар болон эмийн эмчилгээний үр дүн, аюулгүй байдлын бүртгэл хөтөлнө.
- 2.2. Судалгааны баг судалгааны явцад дараах тохиолдлуудад Эмнэлзүйн хороо, Эрсдэлийн удирдлагын хороо болон Эмзүйн албанд холбогдох журмын дагуу мэдээлнэ:
 - 2.2.1. Эмнэлзүйн судалгааны үед үүссэн аливаа ноцтой гаж тохиолдол;
 - 2.2.2. Эмийн эмчилгээний алдааны тохиолдол;
 - 2.2.3. Эмийн эмнэлзүйн судалгааны арга аргачлалд өөрчлөлт орсон үед мэдээлнэ.
- 2.3. Эм зүйн алба “Эм зүйн албаны стандарт үйл ажиллагааны заавар”, “Эм эргүүлэн татах, устгах журам”-ын дагуу, судалгааны эмэнд тусад нь бүртгэлийн маягт, дэвтэр нээж, баримтжуулна:
 - 2.3.1. Эмнэл зүйн судалгаанд хэрэглэсэн эмийн хэрэглээ, түүний хадгалалтын хяналтын тайлан хөтлөх;
 - 2.3.2. Судалгаанд хэрэглэсэн эмийн орлого, зарлага, эргүүлэн татсан болон устгалын тайлан
- 2.4. Судалгааны эм хэрэглэх явцад тохиолдсон эмийн гаж нөлөө, эмийн эмчилгээний алдааны тохиолдлыг “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах журам”, “Тохиолдол мэдээлэх бүртгэх журам”-ын дагуу бүртгэж, мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын
оны.....сарын.....-ны өдрийн
....дугаар тушаалын 16 дугаар хавсралт

Үйлчлүүлэгчийн өөрийн эм хэрэглүүлэх заавар

Эмнэлгийн эмийн жагсаалт болон Монгол Улсад бүртгэгдээгүй, өөр эмээр орлуулах боломжгүй, эмчийн жороор хэрэглэж буй, хэвтэн үйлчлүүлэгчийн эмчилгээнд зайлшгүй шаардлагатай өөрийн эм, эмийн бодисыг эмнэлэгт хэрэглэх болон эмчилгээний хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Үйлчлүүлэгчийн өөрийн эм гэж өмнө үзүүлж, байнгын хяналтад байдаг эмчийн жороор хэрэглэж буй эмийг хэлэх бөгөөд биологийн идэвхт бүтээгдэхүүн юм уу хүнсний нэмэлт тэжээлийг үүнд хамруулахгүй.

Үйл ажиллагаа:

1. Үйлчлүүлэгчийн өөрийн эмийг зөвхөн дараах нөхцөлд эмнэлэгт хэрэглэнэ:
 - 1.1.Тухайн эм нь эмнэлгийн жагсаалт болон эмийн санд байхгүй бөгөөд тухайн эмийг хэрэглэх шаардлагатай тохиолдолд
 - 1.2.Удаан хугацааны, зайлшгүй үргэлжлүүлэх шаардлагатай курс эмчилгээнд хэрэглэж буй тохиолдолд
2. Үйлчлүүлэгчийн өөрийн эмийн аюулгүй байдал болон хэрэглэх зааврын мэдээллийг эмнэлгийн эм зүйн албанаас хянаж, стандартын дагуу шошго наан баталгаажуулна.
3. Үйлчлүүлэгчийн өөрийн эмийг хянасан огноо болон гарын үсгээр баталгаажуулна.
4. Үйлчлүүлэгчийн өөрийн эмийг бүртгэж авах болон буцааж олгох
 - 4.1. Үйлчлүүлэгчийн өөрийн эмийг хэвтэн эмчлүүлэх тасгийн эмийн шүүгээнд хадгалах ба эмнэлгээс гарах хүртэл эмийг үйлчлүүлэгчид буцаан олгохгүй.
 - 4.2. Тасгийн ээлжийн ахлах сувилагч үйлчлүүлэгчийн өөрийн эмийг бүртгэж авч, хадгалах нөхцөлийн зааврын дагуу хадгална.
 - 4.3. Өндөр эрсдэлт эм хэрэглэдэг бол тусгай шүүгээнд хадгална.
 - 4.4. Үйлчлүүлэгч болон сувилагч хоёул өөрийн эмийг бүртгэх хуудсанд гарын үсэг зурна.
 - 4.5. Үйлчлүүлэгч өөрийн эмийг бүртгэх хуудсыг 2 хувь үйлдэж, нэг хувь нь эмийн шүүгээнд эмтэйгээ хамт, нөгөө хувь нь үйлчлүүлэгчийн түүхэнд хавсаргагдана.

- 4.6. Үйлчлүүлэгч өөрийн эмийг бусад эмээс тусад нь “Үйлчлүүлэгчийн гэртээ хэрэглэж байсан эм” гэж хаяглан, шүүгээнд хадгалагдах бөгөөд бусад эмтэй хольж болохгүй.
- 4.7. Үйлчлүүлэгч эмнэлгээс гарах үед нь өөрийн эмийг буцаан олгох бөгөөд үйлчлүүлэгч болон эмнэлгээс гаргаж байгаа сувилагч өөрийн эмийн бүртгэлийн хуудсанд хоёул гарын үсэг зурна.
5. Эмч үйлчлүүлэгчийн өөрийн эмийг эмчилгээнд жор бичихдээ цахим бүртгэлийн эмийн тусгай тэмдэглэлийн хэсэгт, жор бичих журмын дагуу бичнэ.
6. Өөрийн эмийн жоронд дараах зүйл тусгагдсан байна. (хүснэгт 1)
 - 6.1. Жор бичигдсэн огноо
 - 6.2. Үйлчлүүлэгчийн нэр
 - 6.3. Эмийн нэр /олон улсын нэр болон худалдааны нэр/
 - 6.4. Эмийн тун
 - 6.5. Хэрэглэх давтамж
 - 6.6. Хэрэглэх арга
 - 6.7. Өөр бусад тусгай заалт байгаа бол тусгана
 - 6.8. Жор бичигчийн гарын үсэг
 - 6.9. “Үйлчлүүлэгчийн өөрийн эмээс хэрэглэнэ” гэсэн тэмдэглэл байна
7. Үйлчлүүлэгчийн өөрийн эмийг сувилагч жорын дагуу өдөрт хэрэглэх хэмжээгээр олгож, эмчилгээний хуудсанд бүртгэл хөтөлнө.
8. Эмийн эмчилгээг үр дүнтэй, аюулгүй байлгахын тулд үйлчлүүлэгчийг эмнэлэгт байх хугацаанд өөрийн эмийг хэрхэн зохистой хэрэглэх, эсвэл зогсоосон тохиолдолд шаардлагатай мэдээллийг өгнө:
 - 8.1. Эмч үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийнхэнд өөрийн эмийг хэрэглэхийг зөвшөөрсөн эсэх тухай эхний мэдээллийг өгнө.
 - 8.2. Эм зүйч үйлчлүүлэгчийн өөрийн эмийг хэрэглэх зөвлөгөө, мэдээллийг төлөвлөнө.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ӨӨРИЙН ЭМ БҮРТГЭХ ХУУДАС

Жор бичсэн огноо:

Үйлчлүүлэгчийн нэр:

Жор бичсэн эмчийн гарын үсэг:

Тасаг нэгж:

Эмийн нэр /Женерик болон худалдааны нэр/	Эмийн тун, хэлбэр	Эмийн тоо	Хэрэглэх арга, давтамж	Эмийн серийн дугаар, дуусах хугацаа	Эм хэрэглэсэн огноо	Сувилагчийн гарын үсэг	Хянасан эм зүйчийн гарын үсэг

Үйлчлүүлэгчийн гарын үсэг...../...../